

ЎОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

“2018 ОНЫ ТӨСВИЙН ХУУЛИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ”



2018

АУДИТЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

Хууль эрх зүйг чандлан мөрдсөнөөр төсвийг үр дүнтэй төлөвлөж зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах үндэслэл болохоор байна.

АГУУЛГА

[illegible]

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
АТӨЯХАТ	Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар
АУЭХС ТӨХК	Алтай Улиастай Эрчим Хүчний Систем Төрийн өмчит хувьцаат компани
БОАЖЯ	Байгаль орчин аялал жуулчлалын яам
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
БСУГ	Боловсрол Соёл Урлагийн Газар
ГХБХБГ	Газрын Харилцаа Барилга Хот Байгуулалтын Газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУ	Монгол улс
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТТАМАТ	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр
УИХ	Улсын Их Хурал
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
УЦУОШГ	Ус цаг уур орчны шинжилгээний газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах хороо
ЭМТ	Эрүүл мэндийн төв

ХҮСНЭГТЭН ТОВЬЁГ

№	Хүснэгтийн нэр	Хуудас
1	Орон нутгийн нэгдсэн төсөв	6
2	Сургууль, цэцэрлэгийн хувьсах болон нормативт зардлын тооцоо	11
3	Орон нутгийн орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт 3-р улирлын байдлаар	12
4	Зээлийн эргэн төлөлт	14
5	Байр түрээслүүлж байгаа байгууллага	15
6	Барилгын зураг төсвийн товчоо” ОНӨААТҮГ, “Орон сууцны алба” ОНӨААТҮГ-ын санхүүгийн үзүүлэлт	18
7	Орон нутгийн ТЕЗ-ийн нэгтгэсэн тайлангийн 2018 II 09 сарын байдлаарх төсвийн гүйцэтгэл	19
8	Яамдын багцаар гаргасан төсвийн гүйцэтгэл	19
9	Говь-Алтай аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт	24
10	Төсвийн гүйцэтгэлийн тайлан хөтөлбөр, ангиллаар /2018.09.30/	25

ДҮРСЛЭЛИЙН ТОВЬЁГ

№	Дүрслэлийн нэр	Хуудас
1	Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын харьцуулсан судалгаа	7
2	Сумдын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөлт, түүнийг нэмэгдүүлэх боломжийн судалгаа	9
3	Түрээсийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэлийн харьцуулалт	15

Аудит хийх үндэслэл үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2018 оны А/125 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөний 38 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэгт заасан Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

Монгол Улсын 2018 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сан болон Эрүүл мэндийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хуулиудын хэрэгжилтийн явцыг шалгаж, дүгнэлт гарган аймгийн ИТХ, Засаг даргад танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

1. 2018 оны төсвийн орлого, зарлагыг бодитой төлөвлөсөн эсэх
2. 2018 оны төсвийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн эсэх
3. 2018 оны батлагдсан төсвийг зориулалтын дагуу, үр дүнтэй зарцуулж буй эсэх
4. ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, зорилтот түвшин нийцсэн эсэх

Хамарсан хүрээ

Аудитаар аймгийн орон нутгийн ТЕЗ-ийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг нэгж, байгууллагуудын 2018 оны төсвийн төлөвлөлт, 2018 оны 3 дугаар улирлын төсвийн гүйцэтгэлийн тайлан, хэлбэлзэл, судалгаа, мэдээлэл болон бусад холбогдох баримт материалд тулгуурлан гүйцэтгэлээ. Мөн аймгийн Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сангийн хувьд орлого зарлага, төсвийн гүйцэтгэлийн хувьд хамруулж үзсэн.

Аудитын арга зүй

Аудитыг Аудитын Дээд байгууллагуудын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын болон гүйцэтгэлийн аудитын журам, арга зүйг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын судалгаа, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа. Үүнд:

- ✓ Төсвийн орлогын хувьд сумдын бодит бааз суурьт судалгаа хийж орлогын төлөвлөлт үндэслэлтэй эсэх, орлогыг бүрэн төвлөрүүлж байгаа эсэх, орлого нэмэгдүүлэх боломжийг давтан тооцоолсон.
- ✓ Орон нутгийн орлогын хувьд үл хөдлөх албан татвар, үйлчилгээний зориулалтаар ашиглаж байгаа усны төлбөр, газрын төлбөр, Есөнбулаг сумын хогны төлбөрийн төлөвлөлт, бүрдүүлэлтийг нэг бүрчлэн тооцлоо.
- ✓ Төсөвт байгууллагуудын өөрийн болон түрээсийн орлогыг анхан шатны баримтад тулгуурлан тооцоолсон. Мөн “Ундарга-Алтай” ОНӨААТҮГ-ын бизнес төлөвлөгөөнд дүн шинжилгээ хийж тухайн байгууллагын хувьд орлого нэмэгдүүлэх боломжийг судлахын хамт орон нутгийн өмчид бүртгэлтэй авто машины түрээсийн орлогыг орон нутгийн орлогод оруулах судалгааг гаргалаа.
- ✓ Аймгийн “Барилгын зураг төсвийн товчоо”, “Орон сууцны алба” ОНӨААТҮГ-уудыг татан буулгахтай холбоотой хөрөнгө, өр төлбөр, авлагын асуудлыг хууль эрх зүйн хүрээнд бүрэн шийдвэрлэсэн эсэхийг хянаж үзлээ.
- ✓ ОНХС, ОНХО, СХС-ийн 2018 оны төсвийн төлөвлөлтийг Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”, Төсвийн тухай хууль болон бусад хууль эрх зүйн хүрээнд үндэслэлтэй төлөвлөсөн эсэхийг судалж үзлээ.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад төсвийн тогтвортой байдлыг хангасан байх, төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх, санхүү төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх, ил тод байдлыг хангасан байх, хариуцлагатай байх зарчмуудыг баримтална. Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

2018 оны төсвийн төсөлд өгсөн саналын талаар:

МУ-ын 2018 оны төсвийн тухай хууль, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1¹ дэх заалт, Сангийн сайдын 2012 оны “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам батлах тухай” 244 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтын 7 дугаар зүйлийн 7.3² дахь заалтын дагуу аймгийн ИТХ-д өргөн мэдүүлсэн 2018 оны төсвийн төслийг Төрийн аудитын газарт ирүүлжээ. Аймгийн 2018 оны төсвийн төсөлд 606,742.9 мянган төгрөгийн орлого нэмэгдүүлэх 5 санал, 786,318.8 мянган төгрөгийн зардал бууруулах 3 санал, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх 8 зөвлөмжийг аймгийн ИТХ болон Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн байна. /Төсвийн санал-хавсралт-1, 2/

Өгсөн саналаас 5,040.0 мянган төгрөгийн орлого нэмэгдүүлэх 1 санал, 25,000.0 мянган төгрөгийн зардал бууруулах 1 саналыг хүлээн зөвшөөрч аймгийн ИТХ-аар төсвийг хэлэлцүүлэн баталжээ. Говь-Алтай аймгийн орон нутгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны орлого зарлагын төлөвлөлтийн тэнцлийг авч үзвэл дараах байдалтай байна.

Орон нутгийн нэгдсэн төсөв

Хүснэгт-1			мянган.төгрөг
Орон нутгийн орлого, санхүүгийн дэмжлэгийн дүн	57,281,828.2	Орон нутгийн зарлагын дүн	57,281,828.2
Орон нутгийн орлого	6,429,330.6	Аймгийн удирдлагын дүн	3,138,498.2
Төсөвт байгууллагын өөрийн орлого /Боловсрол-78,805.0/	139,915.0	Сумын удирдлагын дүн	6,469,353.1
Санхүүгийн дэмжлэг / улсаас/	11,267,019.1	Халамжийн санд зарцуулах	5,303,714.9
Шилжих үлдэгдлээс санхүүжих / ОНХО/-95099,1	95,099.1	ОНХО-нд зарцуулах	2,979,197.8
Тусгай зориулалтын шилжүүлэг	34,390,788.5	Тусгай зориулалтын шилжүүлэг	34,469,593.5
ОНХНС-аас авах шилжүүлэг	3,399,299.5	ОНХС-д зарцуулах	3,500,739.6
Шилжих үлдэгдлээс санхүүжих /ОНХС/	101,440.1		
Шилжих үлдэгдлээс санхүүжих / СХС/	1,270,731.1	Эргэн төлөгдөх зээл / сум хөгжүүлэх сан/	1,270,731.1
Шилжих үлдэгдлээс санхүүжих / Тусгай сан/	150,000.0	Тусгай санд зарцуулах / МХС, ТЭДС/	150,000.0

Аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн “Аймгийн 2018 оны төсөв батлах тухай” 08 дугаар тогтоол, сумдын ИТХ-ын тогтоолоор аймаг, сумдын орон нутгийн төсвийн зарлага, төсөв захирагчдын төсвийн жилд зарцуулах зардлын дүнг 57,281,828.2 мянган төгрөгөөр, түүнийг санхүүжүүлэх эх үүсвэр орон нутгийн төсвийн орлогын дүнг 6,429,330.6 мянган төгрөг, ТЭЗ, улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 11,267,019.1 мянган төгрөг, ОНХС-д улсын төсвөөс авах орлогын шилжүүлгийг 3,399,299.5 мянган төгрөгөөр, тусгай зориулалтын шилжүүлгийн нийт дүнг 34,469,593.5 мянган төгрөгөөр тус тус баталсан байна.

Мөн сумдад олгох санхүүгийн дэмжлэгийг 5,250,446.0 мянган төгрөг, сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 1,522,202.3 мянган төгрөг, аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж, их засварын зардлын хэмжээг 1,978,537.2 мянган төгрөгөөр тус тус баталжээ.

¹ аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн төслийг жил бүрийн 11 дүгээр сарын 25-ны дотор тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх

² Аймаг нийслэлийн Засаг дарга тухайн шатны төсвийн төслийг аймаг, нийслэлийн аудиторт ИТХ-д жил бүрийн 11 дүгээр сарын 10-ны өдрийн дотор хүргүүлнэ.

Дэд зорилт-1: 2018 оны төсвийн орлого зарлагыг бодитой төлөвлөсөн эсэх

Орлогын боломжит эх үүсвэрүүдийг бүрэн дайчлан төсвийг үр ашигтай хэмнэлттэй төлөвлөх нь зүйтэй юм.


1.1 Говь-Алтай аймгийн төсвийн орлогыг үндэслэлтэй төлөвлөсөн үү?

Аймгийн 2018 оны төсөвт төвлөрүүлэх орлогыг 691,173.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөх боломжтой байна.

Аймаг сумдын ИТХ-ын тогтоолоор аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 5,349,738.0 мянган төгрөг, сумдын орон нутгийн орлогод төвлөрүүлэх орлогыг 1,079,591.0 мянган төгрөг, нийт 6,429,330.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр баталжээ. /ОНО-Хавсралт-1/

Орон нутгийн орлогын төлөвлөлтийн хувьд харилцагч байгууллагууд ажлын уялдаа муутай, орлого нэмэгдүүлэх тал дээр санаачилга гарган ажиллаагүй, орлогын төлөвлөлтийг бодит тоо мэдээнд үндэслэн төлөвлөөгүй хийсвэрээр төлөвлөсөн байна. Орон нутгийн орлогын төлөвлөлтийг бодит бааз суурьт үндэслэн тулган баталгаажуулахад дараах орлогыг дутуу төлөвлөсөн байгаа бөгөөд нэмэгдүүлэн төлөвлөх боломж байна. Тухайлбал:

Дүрслэл №1: Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын харьцуулсан судалгаа /мян.төг/



Аймгийн орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсан орлогыг нэр төрлөөр, татвар төлөгч бүрээр тулган тооцоолоход үл хөдлөх хөрөнгийн татварыг 115,725.1 мянган төгрөгөөр, газрын төлбөрийг 103,933.8 мянган төгрөгөөр, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрийн орлогыг 137,373.6 мянган төгрөгөөр, АТӨЯХАТ-ын орлогыг 3,008.78 мянган төгрөгөөр нийт 360,041.3 мянган төгрөгөөр дутуу төлөвлөсөн буюу орлого нэмэгдүүлэх боломжтой байна. /ОНО-хавсралт-2,3/

Үл хөдлөх хөрөнгийн албан татварын талаар:

Үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлогыг 230,000.0 мянган төгрөгөөр төлөвлөсөн бөгөөд аймгийн хэмжээнд Улсын бүртгэлийн газрын мэдээллийн санд шинээр нэмэгдсэн болон өөрчлөлт орсон үл хөдлөх хөрөнгийн татварын ногдуулалтыг Татварын хэлтэстэй тулган баталгаажуулахад 115,725.0 мянган төгрөгийн татвар нэмэгдэж орох боломжтой байна. Тухайлбал:

- ✓ Цээл сумд байрлах “Алтайн Хүдэр” ХХК-ийн нэр дээр бүртгэлтэй 26 нэр төрлийн 26,432,906.0 мянган төгрөгийн хөрөнгөнд үл хөдлөх хөрөнгийн албан татварыг 98,218.0 мянган төгрөгөөр дутуу ногдуулсан.
- ✓ Цээл сумд байрлах “Майнбласт” ХХК-ийн нэр дээр 4 нэр төрлийн 329,000.0 мянган төгрөгийн үл хөдлөх хөрөнгөнд татвар ногдуулаагүй.

- ✓ Сумдад байрлах “Монсульт” ХХК, “Петровис” ХХК-ийн нэр дээр байрлах объектуудад татвар ногдуулаагүй. Хариуцсан сумын татварын байцаагч “татварыг аймаг дээр нэгдсэн журмаар төлдөг” гэсэн тайлбарыг өгсөн боловч, бодит байдал дээр төлөөгүй.
- ✓ Мөн бүх сумдад иргэн, ААНБ-ын нэр дээр бүртгэлтэй байгаа үйлчилгээний зориулалттай барилга байгууламж, граж, агуулах зэрэг нийт 133 нэр төрлийн 29,590,726.0 мянган төгрөгийн үл хөдлөх хөрөнгөнд татварыг ногдуулаагүй, мөн зөрүүтэй ногдуулсан байна.

Дээрх үл хөдлөх хөрөнгөнд татвар ногдуулахаар төлөвлөөгүй байгаа нь Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1³ дэх заалтыг зөрчсөн байна.

Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр:

Аймгийн хэмжээнд 98,500.0 мянган төгрөгийн усны төлбөрийн орлого орно гэж төлөвлөжээ. Төлөвлөхдөө мэргэжлийн байгууллагын ус ашиглах дүгнэлт, тооцоо судалгаагүйгээр хийсвэрээр тооцсон, 20,000.0 мянган төгрөгийн усны төлбөрийн орлогыг хаанаас орох нь тодорхой бусаар “бусад” гэж төлөвлөсөн байна.

Мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн, аймгийн хэмжээнд ус ашиглаж байгаа иргэн, ААНБ-ын 2016-2018 онд төлөх усны төлбөрийг тооцоог хийж үзэхэд 137,373.6 мянган төгрөгийн орлого нэмж оруулах боломжтой байна. Тухайлбал: “Алтайн Хүдэр” ХХК 28,299.0 сая төгрөг, “Цогц эрин транс” ХХК 5,600.0 мянган төгрөг, “ЭН СИ ЖИ ТИ” ХХК 30,000.0 мянган төгрөг, “Марко поло” ХХК 4,072.0 мянган төгрөг гэх мэт.

Харин батлагдсан үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрийн орлогоос 12,264.9 мянган төгрөгийн орлого орох боломжгүй байна. Үүнд:

- “Эф Ви Эс Пи” ХХК-иас 10,000.0 мянган төгрөгийн орлого орно гэж төлөвлөсөн боловч 141.0 мянган төгрөгийн ус ашиглах дүгнэлт гаргуулсан, үйл ажиллагаа бараг явуулаагүй.
- “Өү Жи Си Эйч Эл” ХХК-иас 3,500.0 мянган төгрөгийн орлого орно гэж төлөвлөсөн боловч үйл ажиллагаа явуулаагүй.
- “Ундарга Алтай” ОНӨААТҮГ дүгнэлтээр 1,869.3 мянган төгрөгийн орлого орохоор байтал 2,000.0 мянган төгрөгийг буюу 130.4 мянган төгрөгийг илүү төлөвлөсөн.

Ус ашиглах дүгнэлтгүй, зөвшөөрөлгүй ашиглаж байгаа иргэн, аж ахуй нэгжүүдэд Усны тухай хууль, Зөрчлийн тухай хуульд заасны дагуу хариуцлага тооцох нь зүйтэй байна. Эдгээр аж ахуйн нэгжүүд дүгнэлтгүй, ус ашигласны төлбөрийн орлогыг төлөхгүй, ус ашигласаар ирсэн нь хяналт сул байсныг харуулж байна.

Газрын төлбөрийн талаар:

Тайланд онд газрын төлбөрийн орлогоос 199,290.4 мянган төгрөгийн орлого орно гэж төлөвлөжээ. Аудитаар тооцоход сумдын газар эзэмшигч иргэн, ААН-үүдийн өмнөх онд төлөөгүй газрын төлбөрийн үлдэгдэл 91,369.1 мянган төгрөг, 2018 онд ногдуулсан төлбөр 211,855.5 мянган төгрөг, нийт 303,227.7 мянган төгрөгийн төлбөрийг оруулахаар төлөвлөх ёстой байна. Гэтэл газрын төлбөрийг төлөвлөхдөө өмнөх 2 жилийн гүйцэтгэлийг үндэслэн төлөвлөсөн, өмнөх онд дутуу төлсөн газрын төлбөрийн орлогыг авлагаар бүртгээгүй байна. Иймээс 2018 онд 103,933.8 мянган төгрөгийн орлого нэмж орох боломжтой байна.

АТӨЯХАТ-ийн талаар:

АТӨЯХАТ-аас 275,000.0 мянган төгрөгийн орлого орно гэж төлөвлөсөн бөгөөд тулган баталгаажуулахад Цээл сум нь 3,008.0 мянган төгрөгийн мотоциклийн татварыг төлөвлөөгүй байгаа учир нэмж орлого орох боломжтой байна.

Сумдын батлагдсан төсвийн орлогыг нэр төрлөөр, бааз сууриар бодит гүйцэтгэлтэй тулган баталгаажуулахад үйл ажиллагааны орлогыг 17,407.0 мянган төгрөгөөр, хөрөнгийн орлогыг 164,663.6 мянган төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамжийн орлогыг 522.8 мянган төгрөгөөр, рашаан, ус ашигласны төлбөрийн орлогыг 199.6 мянган төгрөгөөр, ойгоос мод,

³ Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар ногдуулах үнэлгээг уул хөрөнгийн үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд бүртгэгдсэн үнийн дүнгээр, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд бүртгэгдээгүй бол хөрөнгийн даатгалд даатгуулсан үнийн дүнгээр, хөрөнгийн даатгалд даатгуулаагүй бол данс бүртгэлд бүртгэгдсэн үнийн дүнгээр тус тус тодорхойлно

түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлогыг 386.0 мянган төгрөгөөр, ан агнуурын нөөц ашигласны төлбөрийн орлогыг 61,874.0 мянган төгрөгөөр, ТТАМАТ-ийг 517.0 мянган төгрөгөөр, хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг 88,245.3 мянган төгрөгөөр, татварын бус орлогыг 1,184.4 мянган төгрөгөөр нийт 331,132.5 мянган төгрөгөөр орлогыг нэмэгдүүлэх боломжтой байна. /ОНО-хавсралт-4/

Дүрслэл №2: Сумдын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөлт, түүнийг нэмэгдүүлэх боломжийн судалгаа /мян.төг/



Харин нохойн татварыг 400.0 мянган төгрөгөөр, хөрөнгө борлуулсны орлогыг 500.0 мянган төгрөгөөр, бууны албан татварын орлогыг 54.0 мянган төгрөгөөр, шууд бус орлогыг 659.4 мянган төгрөгөөр, нийт 1,933.8 мянган төгрөгийн орлого орох боломжгүй байхад хий төлөвлөсөн байна.

Орлогын төлөвлөлтийг бодитой тооцоогүй байгаа нь Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газраас гаргасан "Төсвийн Ерөнхийлөн захирагч нарын 2018 оны төсвийн төсөл, 2019-2020 оны төсвийн төсөөлөл бэлтгэх удирдамж"-ийн 4.1⁴ дэх заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байгааг харуулж байна.

1.2 Говь-Алтай аймгийн төсвийн зарлагыг үндэслэлтэй төлөвлөсөн үү?

Төсвийн зарлагыг журам заавар, норм нормативт үндэслэн бодитой төлөвлөөгүйгээс хууль эрх зүй зөрчигдөж зарцуулах эрсдэлийг бий болгож байна.

Аймгийн 2018 оны төсвийг аймгийн ИТХ-ын 2017 оны 12 сарын 4-ны өдөр баталж төсвийн жил зарцуулах зарлагын хэмжээг 54,832,190.0 мянган төгрөгөөр баталжээ.

Аудитаар ОНХС болон ОНХО-аар хийгдэх ажлыг үндэслэлтэй төлөвлөсөн эсэх, аймгийн хэмжээний сургууль, цэцэрлэгүүдийн хувьсах зардал болон хүүхдийн хоол, үдийн цайны нормативт зардлыг тооцож, төлөвлөсөн дүнтэй харьцууллаа.

⁴ МУ-ын төсвийн орлогын бодлого нь 2018 онд тэнцвэрт харьцааг хадгалах хэмжээнд орлогын боломжит эх үүсвэрүүдийг бүрэн дайчлах, төсвийн орлогын тогтвортой бааз суурийг өргөжүүлэх, татвар хураалтыг эрчимжүүлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх, нийгэм эдийн засгийн хөгжлийн зорилтуудыг биелүүлэхэд төсвөөс санхүүжигдэх ажиллагааг хэвийн явуулах эх үүсвэрийг бүрдүүлэхэд чиглэгдэх бөгөөд орлогын төлөвлөгөөг боловсруулахад дараах зарчмыг баримтална. Үүнд: 4.1.3 /Төсвийн орлого бүрдүүлэлтэд нөлөө үзүүлэх үр дагавар бүхий хууль, тогтоомж, бодлогын аливаа шийдвэрийн нөлөөллийг орлогын төлөвлөгөө боловсруулахад тусгах. Тухайлбал: (a), (b), (c)

ОНХС болон ОНХО-аар хийх ажлын төлөвлөлтийн талаар:

Төсвийн жилд аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр нийт 15 ажил, үйлчилгээ, хөтөлбөрт 1,978,537.2 мянган төгрөг, сумдад нийт 129 ажил, үйлчилгээ, хөтөлбөрт 1,522,202.3 мянган төгрөг, нийт 144 ажил, үйлчилгээ, хөтөлбөрт 3,500,739.5 мянган төгрөг баталсан байна.

Сумдад ОНХС-ийг төсөв баталсан байдлыг үзэхэд аймгаас сумдад олгох шилжүүлгийг ИТХ-аар батлахдаа холбогдох хууль дүрэм зааврыг зөрчин сумдын хооронд үндэслэлгүйгээр нэмж хасаж баталсан. Нийт 9 сумаас 103,021.3 мянган төгрөг хасаж, 8 сумд 103.021.3 мянган төгрөг нэмж баталсан байна. /ОНХС-хавсралт-1/

Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6 дугаар зүйлийн 6.3⁵-т зааснаар Төсвийн тухай хуулийн 60.3-т заасан зүйлийг баримталсан эсэх, орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэгт зарцуулахаар төлөвлөсөн эсэх, хөрөнгө, оруулалтын төсөл хөтөлбөр арга хэмжээ нь хуульд заасны дагуу техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн, бусад зөвшөөрөлтэй эсэх, орон нутгийн дунд хугацааны төлөвлөлттэй уялдсан эсэх, иргэдийн оролцоог хангасан байдал зэргийг судаллаа.

ОНХС-ийн заавар болон төсвийн тухай хуульд нийцүүлэн орон нутгийн удирдлагын хэрэгжүүлэх чиг үүрэгт тусгагдсан ажлуудыг баталсан байна. Олон нийтийн оролцоог хангах талаар аймгийн ОНХС болон Халиун, Чандмань, Эрдэнэ сумуудад нийт 204,301.7 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 16 ажлыг иргэдээс санал аваагүй эрэмбэлэгдээгүй төсөл арга хэмжээг шууд ИТХ-аар хэлэлцэн баталсан зөрчлийг эс тооцвол бусад арга хэмжээг батлахдаа иргэдийн оролцоог хангаж батлагдсан маягтаар санал авч, эрэмбэлэлт хийсэн байна.

Харин нийт батлагдсан ажлын 88 хувь буюу 2,924,518.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 110 ажлыг техник эдийн засгийн үндэслэл, төсвийн тооцоолол, төсөвт нөлөөлөх байдлын үнэлгээ хийж, хэрхэн шийдвэрлэх тухай санал тусгаагүйгээр шууд ИТХ-аар төсөв тавьж баталжээ. /ОНХС-хавсралт-2/

Аймгийн ИТХ-ын 2017 оны “2018 оны төсөв батлах тухай” тогтоолоор сумын төвд жишиг гудамж бий болгож, тохижуулах ажлыг 12 сумд хэрэгжүүлэхээр 1,068,184.1 мянган төгрөгийн төсвийн тооцоолол хийж, 2018 онд аймгийн ОНХО-аас 721,269.1 мянган төгрөг баталсан бөгөөд үлдэгдэл эх үүсвэрийг тухайн сумдын ОНХС-аас санхүүжүүлэхээр тусгасан байна. Гэтэл жишиг гудамжийн санхүүжилтэд 10 сумд 286,915.0 мянган төгрөгийн эх үүсвэрийг баталж, Жаргалан, Цогт сумдад 60,000.0 мянган төгрөг батлаагүй, ажил хийгдэхэд үлдэгдэл санхүүжилтийг хаанаас өгөх нь тодорхойгүй байна.

ОНХО-ын тухайд аймагт 2018 онд 2,731,697.8 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 15 төсөл, арга хэмжээг баталсан байна. Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4⁶ дэх заалтад хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгахаар байна. Гэтэл 1,420,098.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 14 ажлын техник эдийн засгийн үндэслэл, төсвийн тооцоолол хийгдээгүй байхад шууд ИТХ-аар төсөв тавьж баталсан байна. /ОНХО-хавсралт-1/

Сургууль, цэцэрлэгийн хувьсах зардал болон хоол үдийн цайны нормативт зардлын төлөвлөлтийн талаар:

МУ-ын ЗГ-ын 2016 оны 242 дугаар тогтоолоор сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг шинэчлэн баталсан байна. Уг тогтоолоор хувьсах зардлын бүрэлдэхүүнд багшийн цалин хөлс, нэмэгдэл, урамшил, ажил олгогчоос төлөх НДШ, 10 нэр бүхий бараа үйлчилгээний

⁵ Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр арга хэмжээг төлөвлөхөд дараахь зүйлсийг баримтална:

⁶ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

бусад зардал орсон байдаг. Мөн ЗГ-ын 2012 оны 106 дугаар “Хоолны зардлын дундаж норматив батлах тухай” тогтоолоор 8-10 цаг ажилладаг цэцэрлэгт хоолны зардал 1650 төгрөг, байрны хүүхдийн хоол 2315 төгрөг, үдийн цай нэг хүүхдэд 600 төгрөгөөр батлагдсаны дагуу дээрх зардлуудыг тооцлоо.

Хувьсах зардлыг тооцохдоо бага, дунд боловсролын сургуульд 2017-2018 оны, 2018-2019 оны хичээлийн жилүүдэд албан сургалт, албан бус сургалт болон дотуур байранд хамрагдсан бодит хүүхдийн тоонд үндэслэн хувьсах зардлын нормативаар тооцон “Ерөнхий боловсрол” хөтөлбөрийн “Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх”, “Дотуур байрны үйлчилгээ”, “Үдийн цай хөтөлбөр” арга хэмжээнүүдийн цалин хөлс, НДШ, бараа үйлчилгээний бусад хувьсах зардал, хоол, үдийн цайны зардалд төлөвлөсөн дүнтэй харьцуулж төлөвлөлтийн зөрүүг гаргасан.

Харин сургуулийн өмнөх боловсролын тухайд мөн 2017-2018 оны, 2018-2019 оны хичээлийн жилүүдэд үндсэн бүлэг, хувилбарт сургалтад хамрагдсан хүүхдийн тоог үндэслэн цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ болон хоолны зардлыг нормативаар тооцон, “Сургуулийн өмнөх боловсрол” хөтөлбөрийн “Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх”, “Ээлжийн бүлэгт хамруулах”, “Нүүдлийн бүлэгт хамруулах”, “Явуулын багшийн үйлчилгээ” арга хэмжээнүүдэд төлөвлөсөн цалин хөлс, НДШ, бараа үйлчилгээний бусад хувьсах зардал, хоолны зардалтай харьцуулж дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт №2 Сургууль, цэцэрлэгийн хувьсах болон нормативт зардлын тооцоо /мян.төг/

дд	Байгууллага	Зардлын зүйл анги	Аудитаар тооцсон хувьсах зардал	БСУГ-ын төлөвлөсөн дүн	Зөрүү			
					Илүү		Дутуу	
					Байгууллагын тоо	мөнгөн дүн	Байгууллагын тоо	мөнгөн дүн
1	Бага, дунд боловсролын сургууль	Цалин хөлс, нэмэгдэл урамшил	4,644,903.6	9,129,350.0	28.0	4,484,446.4		-
		АО-с төлөх НДШ	511,001.8	1,095,522.0	28.0	584,520.2		
2	Сургуулийн өмнөх боловсролын байгууллага	Цалин хөлс, нэмэгдэл урамшил	3,416,927.5	2,226,250.0	29.0	1,190,677.5		
		АО-с төлөх НДШ	375,951.3	267,161.7	29.0	108,789.6		
Нийт /цалин, НДШ/			8,948,784.2	12,718,283.7	114.0	6,368,433.6	-	-
1	Бага, дунд боловсролын сургууль	Бараа үйлчилгээний бусад хувьсах зардал	194,341.0	200,627.8	16.0	11,271.7	12.0	4,984.9
2	Сургуулийн өмнөх боловсролын байгууллага		107,778.8	112,481.9	15.0	6,418.5	14.0	1,715.4
Нийт /Бусад хувьсах зардал/			302,119.8	313,109.7	31.0	17,690.2	26.0	6,700.3
1	Бага, дунд боловсролын сургууль	Хоол	808,905.0	1,345,401.0	24.0	570,767.5	4.0	34,271.5
		Үдийн цай	547,311.6	926,243.2	21.0	384,084.0	7.0	5,152.4
2	Сургуулийн өмнөх боловсролын байгууллага	Хоол	1,167,211.7	851,346.2	2.0	4,707.2	27.0	320,572.7
Нийт /Хоол, үдийн цай/			2,523,428.2	3,122,990.4	47.0	959,558.7	38.0	359,996.5

Дээрх судалгаанаас үзэхэд сургууль, цэцэрлэгийн хувьсах зардлын нормативаар тооцсон цалин хөлс болон ажил олгогчоос төлөх НДШ-ийг төлөвлөсөн дүнтэй харьцуулахад 6,368,433.6 мянган төгрөгөөр илүү төлөвлөгдсөн харагдаж байна. Энэ нь багш нарын цалингийн зардлыг төлөвлөхдөө ЗГ-аас тогтоосон цалингийн шатлал, ангиллын дагуу цалингийн зардлыг төлөвлөдөгтэй холбоотой байна.

Мөн багш нарын цалин 2018 онд нэмэгдсэн байхад Боловсролын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3⁷-д заасны дагуу нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг 2016 оноос хойш өөрчлөөгүй байна. Иймд Боловсролын салбарын хувьд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг баримтлан багшийн цалингийн зардлыг төлөвлөх нь ЗГ-ын 2018 оны “Төрийн зарим албан тушаалын цалингийн сүлжээ, дотоод жишгийг шинэчлэн тогтоох тухай” 264 дүгээр тогтоолоор олгох цалинтай уялдахгүй байна. Цаашид эдгээр зөрчигдөж байгаа асуудлыг хууль эрх зүйн хүрээнд шийдвэрлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамд уламжлах нь зүйтэй юм.

⁷ Сургуулийн өмнөх болон бага, дунд, мэргэжлийн боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг Засгийн газар жил бүр шинэчлэн тогтооно

Бараа үйлчилгээний бусад хувьсах зардлыг нормативаар тооцож, 200.0 мянган төгрөгөөс дээш илүү, дутуу төлөвлөсөн дүнг тулгахад 11 сургуульд 8,499.8 мянган төгрөгөөр илүү, 5 сургуульд 3,410.3 мянган төгрөгөөр дутуу, 12 цэцэрлэгт 3,607.9 мянган төгрөгөөр илүү төлөвлөсөн байна.

Сургуулийн хоолны зардлыг 2018 онд 17 сургуульд 570,767.5 мянган төгрөгөөр илүү, 4 сургуульд 34,271.5 мянган төгрөгөөр дутуу, үдийн цайны зардлыг 19 сургуульд 384,084.0 мянган төгрөгөөр илүү, 7 сургуульд 5,152.4 мянган төгрөгөөр дутуу төлөвлөсөн байна. Энэ нь сургуульд үндэслэлгүйгээр 915,427.6 мянган төгрөг илүү төлөвлөн батлуулж, сургуулиудын хоол, үдийн цайны зардалд хуваарилсан зөрчил үүсэж байгаа төдийгүй улмаар төсвийг зориулалт бусаар зарцуулах үндэслэлийг бий болгосон байна.

Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг нормативт зардлаар бодсон дүнгээс 320,572.6 мянган төгрөгөөр дутуу төлөвлөсөн тооцоо гарсан. Төсвийн мэргэжилтэн нь хоолны зардлыг төлөвлөхдөө хүүхдийн ирцээс шалтгаалж 88 хувиар төлөвлөсөн гэж тайлбарласан. Цэцэрлэгүүд хоолны зардлын дундаж нормативыг баримтлан ажиллаж, өнөөдрийн байдлаар өр төлбөр үүсээгүй байгаагаас үзэхэд цэцэрлэгийн хүүхдийн ирц 100 хувьд хүрэхгүй байдагтай холбоотой байна.

Цаашид эдгээр зардлыг төлөвлөхдөө батлагдсан зардлын нормативыг баримталж, илүү дутуу төлөвлөж, зориулалт бусаар зарцуулдаг асуудлыг зогсоох шаардлагатай байна.

Дэд зорилт-2: 2018 оны төсвийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн эсэх

Төсвийн орлого нэмэгдүүлэх, бүрэн төвлөрүүлэхийн тулд хариуцсан албан тушаалтны ажлын хариуцлагыг нэмэгдүүлж, хамтын ажиллагаа үр нөлөөг дээшлүүлэхээр байна.

2.1 Батлагдсан төсвийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн үү?

Орон нутгийн орлогын төлөвлөгөөг нийт дүнгээр нь тооцвол аймагт 99 хувиар, сумд 145 хувиар биелүүлсэн байгаа хэдий ч 8 нэр төрлийн орлогын төлөвлөгөө 177,541.5 мянган төгрөгөөр тасарчээ.

Орон нутгийн төсөвт 2018 оны 3 дугаар улирлын байдлаар 4,478,794.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлэхээр төлөвлөсөн байна. Аудитаар орлогын дансны хуулгыг сумдаар, нэр төрлөөр нь боловсруулан 09 дүгээр сарын 30-ны өдрөөр тасалбар болгон гүйцэтгэлийг тулган баталгаажуулахад төрийн сангийн орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэл нийт дүнгээрээ татварын орлогын мэдээнээс 424,914.3 мянган төгрөгөөр, аудитаар тооцсон орлогын гүйцэтгэлээс 458,073.7 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй, сумын нэр, орлогын зүйл ангийг зөрүүлж бүртгэсэн байна. /ОНО-хавсралт-5/

Хүснэгт№3: Орон нутгийн орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт 3-р улирлын байдлаар /мян.төг/

Байгууллага	Ангилал	Төлөвлөлт	Гүйцэтгэл	Хувь	Тайлбар
Төрийн сан	Аймаг	3,202,947.2	2,763,081.7	86%	Зөрүүтэй гаргасан
	Сум	1,275,747.5	2,205,213.7	173%	Зөрүүтэй гаргасан
Татвар	Аймаг	3,202,947.2	3,190,412.1	100%	Бодит гүйцэтгэл
	Сум	1,275,747.5	1,811,892.3	142%	Төлөвлөлттэй холбоотой давсан
Аудит	Аймаг	3,202,947.2	3,179,200.6	99%	Хуулгыг боловсруулж гаргасан бодит гүйцэтгэл
	Сум	1,275,747.5	1,856,263.0	145%	

Дээрх хүснэгтээс харахад орлогын бүрдүүлэлтийн тоо мэдээ хоорондоо зөрүүтэй бодит гүйцэтгэлийг гаргахад хүндрэлтэй байсан учир аудитаар бүх сумдын орлогын дансны хуулгыг боловсруулан, төлөвлөсөн орлоготой тулгаж, давсан тасарсан шалтгааныг

тодрууллаа. Аймгийн орон нутгийн орлого: Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татварын бүрдүүлэлт 97%-тай буюу 94,269.1 мянган төгрөгөөр тасарсан хэдий ч үл хөдлөх хөрөнгийн албан татвар, газрын төлбөр, хувь хүний орлогын албан татварын буцаан олголт, АТӨЯХАТ-ын орлогууд давснаар, орлогын бүрдүүлэлт нийт дүнгээрээ 99%-тай байна.

Сумдын орон нутгийн орлого: Ан агнуурын орлогыг төлөвлөөгүйгээс 115,038.6 мянган төгрөг, хөрөнгийн орлогыг бодитоор төлөвлөөгүйгээс 282,709.4 мянган төгрөг, улсын тэмдэгтийн хураамжийн орлого бодит гүйцэтгэлээр 25,240.3 мянган төгрөг, татварын бус орлого бодит гүйцэтгэлээр 146,211.8 мянган төгрөг зэрэг томоохон орлогууд давснаар нийт дүнгээрээ сумдын орлогын бүрдүүлэлт 145%-иар давж биелсэн харагдаж байна. /ОНО-хавсралт-6/

Давсан орлогод нөлөөлсөн гол гол хүчин зүйлс:

- ✚ Үйл ажиллагааны орлого 9,169.1 мянган төгрөгөөр давсан нь Алтай сумд шинээр байгуулагдсан нөхөрлөлөөс орлого орсонтой холбоотой.
- ✚ Хөрөнгийн орлого 282,709.4 мянган төгрөгөөр давсан нь ноос ноолуурын үнэ өндөр байсан, малчид, иргэдийн хадгаламж өссөнтэй холбоотой. Орлогын төлөвлөлтийг хийхдээ холбогдох банк, санхүүгийн байгууллагуудаас авсан бодит мэдээлэлд үндэслэн төсвийн орлогын тооцооллыг боловсруулаагүйгээс бага төлөвлөсөн.
- ✚ Улсын тэмдэгтийн хураамжийн орлого 25,240.3 мянган төгрөгөөр давсан нь бодит гүйцэтгэл.
- ✚ Улсын тэмдэгтийн хураамжийн буцаан олголт 6,000.0 мянган төгрөгөөр хэмнэсэн нь буцаан олголт хийгдээгүйтэй холбоотой.
- ✚ Ойгоос мод түлээ бэлтгэж ашигласны төлбөр 350.0 мянган төгрөгөөр давсан нь Жаргалан сум мод бэлтгэх зөвшөөрөл авч төлбөрийг төвлөрүүлсэн боловч орлогын төлөвлөгөөнд төлөвлөөгүйтэй холбоотой.
- ✚ Сумдад рашаан, ус ашигласны төлбөрийн орлого 1,108.2 мянган төгрөгөөр давсан нь төлөвлөгдөөгүй орлого орж ирсэнтэй холбоотой.
- ✚ Ан агнуурын нөөц ашигласны төлбөрийн орлогыг 115,038.6 мянган төгрөгөөр давсан нь БОАЖЯ-ны сайдын 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/370 дугаар тушаалаар Алтай, Жаргалан, Тонхил, Цогт, Чандмань, Есөнбулаг сумд ан агнах тусгай зөвшөөрөл олгосонтой холбоотой бөгөөд орлогыг төлөвлөөгүй.
- ✚ Хүү торгуулийн орлого 153,653.9 мянган төгрөгөөр давсан нь бодит гүйцэтгэл.
- ✚ Өмч хувьчлалын орлого 36,918.0 мянган төгрөгөөр давсан нь өмнөх оны дутуу төлбөр орж ирсэн, мөн төлөвлөгдөөгүй орлого орсон.
- ✚ Төсөвт газрын өөрийн орлого 9,997.9 мянган төгрөгөөр давсан нь Эрдэнэ, Төгрөг сум, БОАЖГ, Ойн анги, ОНӨГ-аас өөрийн орлого давж орсонтой холбоотой.
- ✚ Хувь хүний орлогын албан татварын буцаалтыг 51,192.6 мянган төгрөгөөр хэмнэсэн нь бодит гүйцэтгэл.
- ✚ Үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлого 19,715.4 мянган төгрөгөөр давсан нь төлөвлөлт үндэслэлгүй хийгдсэнтэй холбоотой буюу төлөвлөгдөөгүй орлого орсонтой.
- ✚ Газрын төлбөрийн орлого 10,272.1 мянган төгрөгөөр давсан нь төлөвлөлт үндэслэлгүй хийгдсэн буюу газрын төлбөрийг бага төлөвлөсөнтэй.
- ✚ АТӨЯХАТ-ын орлого 12,844.9 мянган төгрөгөөр давсан нь 2018 оны байдлаар автомашин тоо нэмэгдсэнтэй холбоотой.

Орлого тасрахад нөлөөлсөн хүчин зүйлс:

- ✚ Хөрөнгө борлуулсны орлого 2,525.6 мянган төгрөгөөр тасарсан нь төлөвлөсөн орлого ороогүй, орох боломжгүй хий төлөвлөсөнтэй холбоотой
- ✚ Шууд бус орлого 21,150.6 мянган төгрөгөөр тасарсан нь оруулахаар төлөвлөсөн орлого ороогүй, хэрэгжилт хангалтгүй

- ✚ Галт зэвсгийн албан татвар 3,763.0 мянган төгрөгөөр тасарсан нь Цагдаагийн газрын галт зэвсгийн бүртгэлд шилжилт хөдөлгөөн хийгддэггүй, эзэмшигч нь давхардсан, мэдээллийн баазыг шинэчлээгүйтэй холбоотой
- ✚ Хог хаягдлын хураамжийн орлого 10,443.5 мянган төгрөгөөр тасарсан нь Есөнбулаг сумын хогны орлогын бүрдүүлэлт хангалтгүй, төлбөрийг тухай бүр айл өрхөөс тооцоо нийлж авдаггүйтэй холбоотой
- ✚ Нохойны албан татварын орлого 285.0 мянган төгрөгөөр тасарсан нь Цээл сум нохойн татвараас 400.0 мянган төгрөгийг орно гэж төлөвлөсөн боловч, бодитоор уг орлого орох боломжгүй байгаатай холбоотой
- ✚ ТТАМАТ-ын орлого 4,162.2 мянган төгрөгөөр тасарсан нь Есөнбулаг сумд орохоор төлөвлөсөн орлого ороогүйтэй холбоотой.
- ✚ Түрээсийн орлого 12,787.4 мянган төгрөгөөр тасарсан нь ГХБХБГ нь шинэ байранд орсон, “Хүрийн овоо” ХХК-аас гражийн түрээсийн төлбөр ороогүйтэй холбоотой.
- ✚ Цалин хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлого 94,269.8 мянган төгрөгөөр тасарсан нь ХХОАТ-ын тухай хуульд 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн өөрчлөлтийн дагуу албан татвар ногдуулах жилийн орлогын төлөвлөгөөг боловсруулаагүйтэй холбоотой.
- ✚ Нэр зааж ангилагдаагүй бусад орлого 4,652.6 мянган төгрөгөөр тасарсан нь УИХ-ын гишүүний багцаас олгосон зээлийн эргэн төлөлтөөс төвлөрүүлэхээр төлөвлөсөн орлого ороогүйтэй холбоотой.
- ✚ Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай ашигласан усны төлбөр 23,501.8 мянган төгрөгөөр тасарсан нь үйл ажиллагаа явуулаагүй ААН-ээс төлбөр авна гэж төлөвлөсөнтэй, мөн ус ашиглаж байгаа иргэн ААН-үүдэд тавих хяналт сул байгаагаас төлбөрийг тухай бүр төлөөгүйтэй тус тус холбоотой байна.

Өмнөх жилийн санхүүгийн аудитаар орон нутгийн төсвийн орлогыг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлэх тал дээр анхаарч ажиллах талаар албан шаардлага хүргүүлж байсан боловч энэ жилийн төсвийн орлогын нэр төрлийн гүйцэтгэлээс харахад шийдвэрийн биелэлт хангалтгүй байна. Орон нутгийн орлогын тасарсан шалтгаанаас үзэхэд орлогын төлөвлөгөөг үндэслэлгүй төлөвлөснөөс гадна татварын орлого оруулах эрх бүхий албан тушаалтны хариуцлагагүй ажилласантай холбоотой байна гэж үзлээ.

Бусад орлогын талаар:

“УИХ-ын гишүүдэд 2009-2011 онуудад хуваарилагдсан хөрөнгөөр орон нутагт хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлын үр дүн”-д 2012 онд хийгдсэн гүйцэтгэлийн аудитаар жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор иргэд, хоршоо, аж ахуйн нэгжид олгосон зээлийн эргэн төлүүлээгүй 1,008,732.9 мянган төгрөгийг төлүүлэх албан шаардлага хүргүүлсний дагуу иргэд, хоршоо, аж ахуйн нэгжүүдтэй зөвшилцөн график гаргуулан эргүүлэн төлүүлэхээр шийдвэр гарсан байна. Мөн 2012 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар жижиг дунд үйлдвэрлэл, эрчимжсэн газар тариалан, жимс жимсгэнэ, хүлэмжийн аж ахуйг дэмжих зорилгоор хоршоо, иргэдэд буцаан төлөгдөх нөхцөлтэйгөөр дахин зээл олгосноос 2013 оны байдлаар 431,100.0 мянган төгрөгийг төлүүлээгүйд буцаан төлүүлэх шийдвэр гаргасан байна. Зээлийн эргэн төлөлтийг дараах хүснэгтээр харуулъя.

Хүснэгт №4

Зээлийн эргэн төлөлт /мян.төгрөг/

ДД	Зээлийн зориулалт	Хөрөнгийн эх үүсвэр	Зээлийн хэмжээ	Төлөгдсөн дүн	Төлөгдөөгүй үлдэгдэл
1	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	УИХ-ын гишүүдэд хуваарилагдсан хөрөнгө	1,008,732.9	604,741.3	403,991.6
2	Жижиг дунд үйлдвэрлэл, эрчимжсэн газар тариалан, жимс жимсгэнэ, хүлэмжийн аж ахуйг дэмжих	УТХО	435,100.0	55,888.0	379,212.0
ДҮН			1,443,832.9	660,629.3	783,203.6

Дээрх зээлүүдээс эргэн төлөгдөх хугацаа дууссан боловч одоогийн байдлаар 55 иргэн, аж ахуйн нэгж, хоршоотой холбоотой нийт 783,203.6 мянган төгрөгийн зээлийг төлүүлээгүй нь бусад орлогын төлөвлөгөө тасрах үндсэн шалтгаан болж байгаа тул зээлийг төлүүлэх арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага бий болж байна.

Нийт төлөгдөөгүй 783,203.6 мянган төгрөгийн зээлийн үлдэгдлээс 636,103.6 сая төгрөгийн зээлийг шүүхийн шийдвэр гаргуулж Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн газраар барагдуулах арга хэмжээ авч байгаа бол 11 зээлдэгчийн 147,100.0 мянган төгрөгийн зээлийг төлүүлэхээр ямар ч арга хэмжээ аваагүй байна. /УИХ-ЖДҮД Зээл-хавсралт-1/

2.2 Төсөвт байгууллагуудад орлого нэмэгдүүлэх боломж байсан уу?

Төсөвт байгууллагын орлогын эх үүсвэрийг зөв тодорхойлсноор орон нутгийн төсвийн орлого нэмэгдэх боломжтой байна.

Түрээсийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаар

Батлагдсан түрээсийн орлогын төлөвлөгөөг эх үүсвэр талаас нь судлахад 2018 оны 3 дугаар улирлын байдлаар 37,484.0 мянган төгрөгийн түрээсийн төлбөр төвлөрүүлэх гэрээ байгуулагдсан байна. Гүйцэтгэлээр 39,184.5 мянган төгрөгийн түрээсийн төлбөр төвлөрөх боломжтой байна.

Чандмань сумд 300.0 мянган төгрөгийн түрээсийн орлого олох төлөвлөгөө батлагдсан боловч гүйцэтгэлээр түрээслэгч гэрээгээ сунгаагүй, байраа түрээслүүлээгүйгээс төлөвлөгөө тасрах эрсдэлтэй байна.

Орлогын төлөвлөгөөнд батлагдаагүй боловч орон нутгийн өмчийн байр түрээслүүлэн орлого олдог дараах газрууд байна. Үүнд:

Хүснэгт №5 Байр түрээслүүлж байгаа байгууллага

Түрээслүүлэгч	Түрээслэгч
Аймгийн ЗДТГ	ГХБХБГ
БОАЖГ	
ОНӨГ	Бонавита ХХК
Баянуул сумын сургууль	Баян дүнх ХХК
Бигэр сумын ЗДТГ	Хувь хүн
Жаргалан сумын ЗДТГ	Төрийн банк
Төгрөг сумын ЗДТГ	Төрийн банк
Халиун сумын ЗДТГ	Төрийн банк
Шарга сумын ЗДТГ	Хувь хүн

түрээсийн орлогын 60 хувийг орон нутгийн төсөвт, 40 хувийг тухайн байгууллагад оруулахаар заасан байна. Энэхүү тогтоолын дагуу аймаг сумдын ерөнхий орлогын дансанд түрээсийн төлөгдөөгүй төлбөр болох 22,511.6 мянган төгрөг, байр эзэмшигч байгууллагын дансанд 4,506.2 мянган төгрөг орохоор байна. Түрээсийн төлбөр гэрээний дагуу төлөгдсөн боловч тогтоолд заасан хувиар тооцвол Есөнбулаг, Тонхил, Гуулин тосгоны ерөнхий орлогоос байр эзэмшигч байгууллагын данс руу 993.9 мянган төгрөг, байр эзэмшигч байгууллагын данснаас 3,683.0 мянган төгрөг ерөнхий орлогын данс руу төвлөрөхөөр байна.

Дүрслэл №3:

Түрээсийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэлийн харьцуулалт



Өөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаар

Төгрөг сум ундны усаа зөөвөрлөн сумын айл өрх албан байгууллагыг усаар хангадаг ба үүнтэй холбоотойгоор усны жолооч түгээгчийн орон тоотой ажиллаж байна. Сумын ИТХ-ын тогтоолоор байгууллагад 1 литр усыг 75 төгрөг, айл өрхөд 3 төгрөгөөр борлуулах шийдвэр гарсан ба тогтоолын хэрэгжилтийг үзэхэд 4,065.1 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлээгүй байна. Эрдэнэ сум ОНХСангаар бэлтгэсэн трактороор үйлчилгээ үзүүлдэг, мөн туслах үйл ажиллагаанаас малын ноос ноолуурын орлого оруулдаг бөгөөд гүйцэтгэлийг гаргахад ямааны ноолуурын орлогоос 703.5 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна. Жаргалан сумын өөрийн орлогын эх үүсвэрт түрээсийн төлбөр оруулахаар тооцож баталжээ.

Дээрх 2 сумаас бусад сумдад өөрийн орлогын төлөвлөгөөг 200.0 мянган төгрөгөөр жигд төлөвлөсөн байна. Сумд өөрийн орлогын төлөвлөгөөг ЗДТГ-ын жолоочид төлөвлөгөө өгөх, ЗДТГ-ын дэргэдэх буудлыг ажиллуулж орлого олох, тендерийн материал зарж орлого олох, баяр наадмын зөвшөөрөл хийж зарах гэх мэтээр бүрдүүлжээ. Бигэр, Дэлгэр, Халиун Шарга сумдад өөрийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх орлого олох эх үүсвэр байхгүй байна. Өөрийн орлогын эх үүсвэр байхгүйн улмаас өөрийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх, нэмэгдүүлэх боломжгүй байдаг талаар сумдад ажиллах үед санал гаргаж байсан хэдий ч аудитын хугацаанд өөрийн орлогын эх үүсвэр бүрдүүлэлтийг үзэхэд ажилд хандах хандлага, санхүүгийн албаны ажлын зохион байгуулалт, ажлын хуваарилалтыг нарийн төлөвлөгөөтэй гаргасан сум байхад эх үүсвэртэй хэдий боловч орлого оруулах сонирхолгүй газар байсныг дурдах нь зүйтэй юм. Орлогын төлөвлөлт хийхдээ сумдад өөрийн орлогын төлөвлөгөөг нэгдсэн журмаар 200.0 мянган төгрөгөөр тооцож байгаа нь сумдын онцлог эх үүсвэрийг харгалзахгүй байгаа нэг хэлбэр юм. Цаашид орлогын төлөвлөгөө батлахдаа орж байгаа орлогын эх үүсвэрийг зөв тодорхойлж орлогын нэр төрлийг зөв төлөвлөх, эх үүсвэргүй сумдад өөрийн орлогын төлөвлөгөө батлахгүй байх нь төсвийн гүйцэтгэлд шууд нөлөөлөхийг анхаарч хариуцлагатай хандах шаардлагатай юм.

2.3 Төрийн өмчийн оролцоотой байгууллагуудад орлого нэмэгдүүлэх боломж байсан уу?

ОНТҮГ, ОНӨААТҮГ-уудын ашигт ажиллагааны түвшнийг тодорхойлж, төсвөөс дэмжлэг авалгүй өөрийн эх үүсвэрээр үйл ажиллагаагаа бүрэн явуулах боломжийг судлан хэрэгжүүлэх шаардлага тулгарсан байна.

“Ундрага Алтай” ОНӨААТҮГГазар

Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2017 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн тогтоолоор “Ундарга-Алтай ОНӨААТҮГ-ын цэвэр, бохир усны үйлчилгээний тариф, суурь хураамж батлах тухай” шийдвэрийн дагуу тоолуургүй айл өрхийн тариф төгрөг /хүн.сар байсныг төг/ литрт шилжүүлэн Байгаль орчин ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын А/301 тоот тушаалаар батлагдсан усны нормыг мөрдүүлж ажиллах шийдвэр Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2017 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн 02/293 дугаар мэдэгдлээр ирсний дагуу “Ундарга-Алтай” ОНӨААТҮГГазар нь 2018 оны 6 дугаар сараас орон сууцанд амьдардаг усны тоолуургүй айл өрхийн усны үнийг нэмсэн байна. Энэ дагуу тус газрын бизнес төлөвлөгөөг 10,384.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байгаа хэдий ч уг боломжид дараах сөрөг тал байна.

Орон сууц, нийтийн байр, гэр хорооллын усны нормын дагуу хүйтэн ус хангамж, ариутгах татуургын системд холбогдсон нийтийн байрны хоногийн дундаж нормыг л/хоног/хүн-80 гэж тогтоосон байна. Энэ тооцоогоор орон сууцанд амьдардаг усны тоолуургүй өрхийн нэг хүн /хүүхэд, том хүн ялгаагүй/ сард 2.4 тонн ус хэрэглэхээр тооцож үнэ авч байна. Аудитаар нормын дагуу тоолуургүй айлын жилийн хэрэглээг усны нөөцтэй холбон судлах байсан боловч усны нөөц хариуцсан ажилтан чөлөөтэй, гадаад улсад байснаас хамруулж үзээгүй болно. Манай аймгийн тухайд усан зөөвөр, гүний худгаас усаа

хангадаг, ундны усаа худалдаж авдаг зэрэг онцлог байдлаа харгалзан үзэх, хэрэглэгчдийг усны тоолууржуулах ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.

“Ундарга-Алтай” ОНӨААТҮГ-т 2018 онд орсон орлогын задаргааг гаргахад тус газар нь автомашин, механизм түрээслэн 6,290.7 мянган төгрөгийн орлого олжээ. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн 51 дүгээр тогтоол, 2011 оны 12 сарын 20-ны өдрийн 68 дугаар тогтоолын “2-ын Д”-д нийт түрээсийн орлогын 60 хувийг орон нутгийн төсөвт, 40 хувийг тухайн байгууллагад оруулах шийдвэрийн дагуу тус газрын түрээсийн орлогын 60 хувь болох 3,774.4 мянган төгрөг орон нутгийн орлогод төвлөрүүлэхээр байна.

Тус газрын баланст бүртгэлтэй 653,071.0 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй өмнөх 3-5 жилд ашиглаагүй, ашиглалтын хугацаа дуусахаас өмнө эвдэрч гэмтсэн жилд 35,451.3 мянган төгрөгийн элэгдэл тооцогддог хөрөнгийг орон нутгийн өмчөөс зөвшөөрөл авсны үндсэн дээр шилжүүлэх, дуудлага худалдаанд оруулах зэргээр эргэлтэд оруулснаар хуримтлагдсан элэгдлийн зардлыг бууруулах, цаашлаад орлого олох боломж байна.

Мөн тус газрын бизнес төлөвлөгөөнд баяр ёслолд 10,840.0 мянган төгрөг, зар сурталчилгааны зардалд 2,800.0 мянган төгрөг зарцуулах төсөв батлагдсан байгаа нь УИХ-ын 29 дүгээр тогтоолыг зөрчих эрсдэл үүсгэж байгаа тул санхүүгийн аудитаар нарийвчлан үзэх шаардлагатай гэж үзлээ.

“Гэгээн нуур цэвэр ус” ОНӨААТҮГ Газар

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоолоор 2015 онд нэг торх усны үнийг 0.5 мянган төгрөгөөр тогтоосон байна. Тус үйлдвэрийн газрын алдагдлыг нөхөх зорилгоор жил бүр төсвөөс 150,000.0-200,000.0 мянган төгрөгийн төсвийн дэмжлэгийг олгож иржээ. 2018 оны 3-р улирлын байдлаар 100,000.0 мянган төгрөгийн дэмжлэг авсан байна. Тайлант улирлын байдлаар тус үйлдвэрийн газар нь 0.5 литрийн уснаас 0.16 мянган төгрөгийн ашиг олж 19.8 литрийн уснаас 0.74 мянган төгрөгийн алдагдал хүлээж байгаа борлуулалтын тооцоо ирүүлжээ.

Бага литрийн усны үйлдвэрлэл, төрлийг нэмэгдүүлснээр алдагдлын түвшнийг бууруулах боломжтой санхүүгийн үзүүлэлттэй байна. Тус үйлдвэрийн газрын үйлдвэрлэлийг нэмэгдүүлснээр төсвөөс авах дэмжлэгийг бууруулах, шаардлагатай бол усны зах зээлийн ханшийг бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байгаа өртгийн хэмжээнд хүргэхэд үйлдвэр төсвөөс дэмжлэг авахгүй өөрөө өөрийгөө санхүүжүүлэн ажиллах боломжтой юм.

Иймд тус үйлдвэрийн газрын нэгж бэлэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд гарч буй зардал өртгийн тооцооллыг зах зээлийн ханшийн нэмэгдлийг оруулан тооцож төсвөөс авах дэмжлэгийн хэмжээг бууруулах арга замыг тодорхойлох шаардлагатай байна.

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас тус үйлдвэрийн газрын нэгж бүтээгдэхүүний өртгийг аудитаар тооцоогүй бөгөөд байгууллагын ирүүлсэн мэдээллийн хэмжээнд дүн дүгнэлт боловсруулсан болно.

“Нийтлэг үйлчилгээ” ОНТҮГ

“Нийтлэг үйлчилгээ” ОНТҮГ-ын орлого зардлын төлөвлөгөөг тайлант жилд 259,000.0 мянган төгрөгөөр баталж эхний 6 сарын гүйцэтгэлд аймгийн тамгын газраас хяналт тавьж, санхүүгийн гүйлгээг гүйцэтгэж ажилласан байна. Тус газарт аймгийн ЗДТГ-ын байрны жижиг түрээс, заал түрээс, “Хүнхэр” амралтын газрын гал тогооны түрээсийн орлого олж үйл ажиллагаандаа зарцуулжээ. Тайлант онд гарсан томоохон зардал байхгүй бөгөөд шинээр их хэмжээний авлага, өр үүсгээгүй ажилласан байна. Иймд “Нийтлэг үйлчилгээ” ОНТҮГ-ын бүтцийг аймгийн ЗДТГ-т оруулж чиг үүргийн тухайд давхцаж байгаа удирдлагын зардлыг хэмнэх санал оруулж байна.

Татан буугдсан ААНБ-ын талаар:

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 08 дугаар сарын 24-ны өдрийн 80 дугаар тогтоолоор “Орон сууцны алба” ОНӨААТҮГ, “Барилгын зураг төсвийн товчоо”-г татан буулгах шийдвэр гарсан байна.

“Барилгын зураг төсвийн товчоо” ОНӨААТҮГ, “Орон сууцны алба” ОНӨААТҮГ-ын татан буулгах үед дуусгалтын баланс гаргаагүй бөгөөд ТЕЗ-ийн 2017 оны тайланд нэгтгэгдсэн санхүүгийн үзүүлэлтийг дараах хүснэгтээр харууллаа. Үүнд:

Хүснэгт №6

Санхүүгийн үзүүлэлт /мян.төгрөг/

д/д	Байгууллагын нэр	Санхүүгийн байдлын тайлан				
		Мөнгөн хөрөнгө	авлага	Бараа материал	Үндсэн хөрөнгө	өглөг
1	“Орон сууцны алба” ОНӨААТҮГ	0	0	2,882.3	6,236.6	12,612.7
2	“Барилга зураг зүйн товчоо” ОНӨААТҮГ	29.2	31,355.9	391,198.5	9,191.2	19,796.5
	Нийт дүн	29.2	31,355.9	394,080.8	15,427.8	32,409.2

Татан буулгах комиссын гишүүд “Барилгын зураг төсвийн товчоо”-ны ашиглаж байсан 6 нэр төрлийн эд хөрөнгө, улсын бүртгэлийн гэрчилгээ, тамга зэргийг хүлээн авч хөрөнгө хүлээлцсэн акт үйлджээ. “Орон сууцны алба” ОНӨААТҮГ-ын ашиглаж байсан 5 нэр төрлийн эд хөрөнгийг хүлээн авч хөрөнгө хүлээлцсэн акт үйлдсэн байгаа боловч тус байгууллагаас ямар нэгэн төлөөлөл ирж хүлээлцээгүй, үйл ажиллагаатай холбоотой санхүүгийн баримт, өмч эд хөрөнгө, бусад холбогдох баримт бичиг, тамга тэмдгийг хүлээлгэж өгөөгүй байна.

Татан буулгах комисс нь 2017 оны 08 дугаар сарын 29-нд “Орон сууцны алба” ОНӨААТҮГ-ын дарга мэдэгдэл хүргүүлсэн боловч өнөөдрийн хүртэл баримт материалыг өгөхгүй, мэдэгдлийг биелүүлээгүй, аймгийн Цагдаагийн газарт 4 удаа албан бичиг, хүсэлт хүргүүлсэн боловч шийдвэр гараагүй байна.

2017 оны ТЕЗ-ийн нэгтгэсэн тайлангаар аймгийн ИТХ-ын даргад “ААНБ-ыг татан буулгах комиссын үйл ажиллагаанд хяналт тавьж татан буугдаж байгаа аж ахуйн нэгжүүдийн авлага, өр төлбөрийг барагдуулах ажлыг эрчимжүүлж дуусгалтын тооцоо тайланг албан ёсоор гаргах ажлыг зохион байгуулах” зөвлөмж хүргүүлсэн боловч шийдвэрийг хэрэгжүүлээгүй байна.

Дэд зорилт-3: 2018 оны батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулж буй эсэх

Төсвийн тухай болон холбогдох хууль эрх зүйг баримтлан төсвийг зориулалтын дагуу, үр дүнтэй зарцуулах нь чухал юм.

3.1 ТЕЗ-ийн 2018 оны төсвийн зарлагын гүйцэтгэл, түүний хэтрэлт хэмнэлтийн шалтгаан бодитой, үнэн зөв байна уу?

Төсвийн хэмнэлтийн 50 хувь нь ОНХО, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж байгаа ажлын санхүүжилтээс шалтгаалсан, 15 хувь нь сум хөгжүүлэх сангийн зээл олголттой холбоотой бодит бус хэмнэлт байна.

Аймаг сумдын ИТХ-ын тогтоолоор аймгийн төсвийн нийт зарлагыг 57,281,828.2 мянган төгрөгөөр баталсан байна. Батлагдсан төсвийн дагуу 2018 оны 3 дугаар улирлын байдлаар зарлагын гүйцэтгэлийн төлөвлөгөө 47,407,250.9 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэлээр 41,061,570.8 мянган төгрөгийн зардал гарсан байна. Төсвийн гүйцэтгэлээр хэмнэлт 6,345,680.0 мянган төгрөг байгаа бөгөөд өглөг, авлагыг тооцож бодит хэтрэлт хэмнэлтийг тооцон үзэхэд 5,964,035.4 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

Орон нутгийн ТЕЗ-ийн нэгтгэсэн тайлангийн батлагдсан төсвийн гүйцэтгэлийг Сангийн сайдын 2016 оны “Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай” 07 дугаар тушаалын дагуу эдийн засгийн ангиллаар, бүлгийн дүнгээр авч үзвэл дараах байдалтай байна.

Орон нутгийн ТЕЗ-ийн нэгтгэсэн тайлангийн 2018 ий 09 сарын байдлаарх төсвийн гүйцэтгэл
Хүснэгт №7 мян.төгрөг

Эдийн засгийн ангилал	Зардлын зүйл анги бүлгээр	Батлагдсан төлөвлөгөө /9.30-ны байдлаар/	Гүйцэтгэл /9.30-ны байдлаар/				Зөрүү / төсөв хэмнэсэн+ хэтэрсэн-/
			Гүйцэтгэл /9.30-ны байдлаар/	Өглөг	Авлага	Бодит гүйцэтгэл /9.30-ны байдлаар/	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	19,295,196.0	18,837,100	166,343.2	20,158.0	18,983,285	311,910.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,341,459.8	2,256,482.0	24,472.7	-	2,280,954.7	60,505.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,541,302.0	2,978,225.2	54,052.9	-	3,032,278.1	509,023.9
2104	Хангамж, бараа материалын зардал	946,307.6	816,930.4	77,026.5	-	893,956.9	52,350.7
2105	Нормативт зардал	1,228,295.5	1,063,614.3	42,280.7	-	1,105,894.9	122,400.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	949,883.3	630,876.0	6,700.0	-	637,576.0	312,307.3
2107	Томилолт, зочны зардал	213,924.2	176,107.6	12,605.5	-	188,713.1	25,211.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,372,866.4	950,369.9	1,028.6	-	951,398.5	421,467.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	491,567.6	409,727.1	7,834.7	-	417,561.8	74,005.8
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	17,250.3	15,333.6	-	-	15,333.6	1,916.7
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	4,325,188.3	4,312,725.9	-	-	4,312,725.9	12,462.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,237,277.5	5,010,132.9	9,457.8	-	5,019,590.7	1,217,686.8
2200	Бусад хөрөнгө	4,974,482.7	3,053,765.7	-	-	3,053,765.7	1,920,717.0
230001	Эргэж төлөгдөх зээл	1,472,249.3	550,180.1	-	-	550,180.1	922,069.2
210	НИЙТ ЗАРДАЛ	47,407,250.9	41,061,570.9	401,802.6	20,158.0	41,443,215.5	5,964,035.4

Нийт хэмнэлтийн 6 хувийг цалин хөлс, ажил олгогчоос олгох нийгмийн даатгалын шимтгэл, 9 хувийг байр ашиглалттай холбоотой зардал, 7 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал, 20 хувийг бусад урсгал шилжүүлэг, 30 хувийг бусад хөрөнгийн зардал, 15 хувийг эргэж төлөгдөх зээл эзэлж байна.

Яамдын багцаар гаргасан төсвийн гүйцэтгэл

Хүснэгт №8			Гүйцэтгэл /9.30-ны байдлаар/				Зөрүү / төсөв хэмнэсэн+ хэтэрсэн-/
№	Багц	Батлагдсан төлөвлөгөө /9.30-ны байдлаар/	Гүйцэтгэл /9.30-ны байдлаар/	Өглөг	Авлага	Бодит гүйцэтгэл /9.30-ны байдлаар/	
1	Орон нутгийн засаг захиргаа	22,561,214.00	18,383,797.7	71,536.2	20,158.0	18,435,175.9	4,126,038.1
2	Барилга хот байгуулалтын сайд	260,481.7	226,261.4	5,518.8	-	231,780.2	28,701.5
3	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд	20,874,383.6	19,106,672.8	268,217.1	-	19,374,889.9	1,499,493.7
4	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд	425,023.3	334,355.7	-	-	334,355.7	90,667.6
5	Эрүүл мэндийн сайд	3,286,148.3	3,010,483.3	56,530.5	-	3,067,013.8	219,134.5
	Нийт	47,407,250.9	41,061,570.9	401,802.6	20,158.0	41,443,215.5	5,964,035.4

Нийт хэмнэлтийн 69.2 хувийг орон нутгийн засаг захиргаа, 1 хувийг барилга хот байгуулалтын сайдын багц, 25.1 хувийг боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын багц, 1.6 хувийг хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын багц, 3.7 хувийг эрүүл мэндийн сайдын багц эзэлж байна.

Эрүүл мэндийн даатгалын сан

Аймгийн хэмжээнд 3 дугаар улирлын байдлаар эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг 1,876,243,3 мянган төгрөгөөр төлөвлөснөөс 1,954,517.1 мянган төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөөг 104 хувиар буюу 154,230,230.5 мянган төгрөгөөр төлөвлөгөө давж биелүүлсэн байна. Эрүүл мэндийн даатгалын сангийн шимтгэлийн орлогын 83 хувь буюу 1,613,152.4 мянган төгрөгийг ажил олгогч, даатгуулагчаас орсон орлогоос, 17 хувь буюу 341,364.7 мянган төгрөгийг хувиараа даатгуулагчдын орлогоос тус тус бүрдүүлжээ. Эрүүл мэндийн даатгалын сан 2,186,509.9 мянган төгрөг зарлагын гүйцэтгэл гарч төлөвлөгөөг 92,030.7 мянган төгрөгийг хэмнэсэн үзүүлэлттэй байна.

Нийгмийн даатгалын сан

Аймгийн хэмжээнд 3 дугаар улирлын байдлаар нийгмийн даатгалын сангийн орлогыг 10,561,966.6 мянган төгрөгөөр төлөвлөснөөс 10,290,037.4 мянган төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөөг 97 хувиар биелүүлсэн байна. Нийгмийн даатгалын сан 21,282,765.7 мянган төгрөг зарлагын гүйцэтгэл гарч төлөвлөгөөнөөс 1,137,559.3 мянган төгрөгийг хэмнэсэн үзүүлэлттэй байна.

3.2 Төсвийг зарцуулахдаа Төсвийн болон ТБОНӨХБАҮХА тухай хуулийг хэрэгжүүлж байна уу?

Төсөвт байгууллагууд ТБОНӨХБАҮХА тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 3.1⁸, 8.4⁹, 33.1¹⁰, 33.2¹¹ 8.2¹² дахь заалтуудыг мөрдлөг болгон төсөвт байгууллагуудын 10.0 сая төгрөгөөр дээш өртөгтэй хоол, үдийн цай, түлш, тээвэр шатахууны зардлын хувьд худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан эсэхийг судалж үзлээ. Үүнд: /ХАА-Хавсралт-1, 2, 3, 4, 5/

- ✓ Бугат, Төгрөг сумдын сургууль, цэцэрлэг, Тахийн тал, Алтансоёмбо, Олонбулагын бага сургууль нь худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүйгээр 103,188.7 мянган төгрөгийн хүнсний материалыг шууд худалдан авалт хийсэн.
- ✓ Дарив, Хөхморьт сум, Баянтоорой тосгоны сургууль, цэцэрлэг, Дэлгэр, Халиун сумын сургууль, 2 дугаар сургууль, 3 дугаар сургууль, Гуулин тосгоны цэцэрлэг, 1 дүгээр цэцэрлэг нь хүнсний материал худалдан авах тендер зарласан боловч оролцогч ирээгүй шууд гэрээ байгуулан худалдан авалтыг хийсэн байна.
- ✓ Сумдын нам даралтын зуухтай төсөвт байгууллагуудын хувьд 627,132.0 мянган төгрөгийн түлшийг худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүйгээр шууд худалдан авалт хийсэн.
- ✓ Төсөвт байгууллагууд 397,805.0 мянган төгрөгийн шатахууныг худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүйгээр шууд худалдан авалт хийсэн байна.
- ✓ Аймгийн төвийн сургууль, цэцэрлэгүүд нь худалдан авах бараа үйлчилгээний тендер шалгаруулалтын тендерийн баримт бичгийн үнэ 2,250.0 мянган төгрөгийг бэлнээр авч зарцуулсан байна.
- ✓ Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан баримт бичгийг харахад ажлын хэсэг байгуулахдаа гишүүдийн тоог тэгш тоотойгоор байгуулсан, АЗ сертификаттай гишүүн байхгүй байх, тендер шалгаруулалтын аргыг буруу сонгох, хуульд заасан хугацааг баримтлаагүй байх зэрэг зөрчилтэй асуудлууд байна.

⁸ 3.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө.

⁹ 8.4 Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг

¹⁰ 33.1.Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно.

¹¹ 33.2 Харьцуулалтын аргыг дараахь байдлаар хэрэглэнэ:33.2.1.техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хангаж байгаа 3 болон түүнээс дээш этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдэх; 33.2.2.техникийн болон бусад нөхцөл шаардлагыг хангаж байгаа хамгийн бага үнэ санал болгосон тендер оролцогчид энэ хуулийн 29.1-д заасны дагуу гэрээ байгуулах эрх олгох.

¹² 8.2.Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ.

3.3 Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын зардлыг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулж байна уу?

УТХО, ОНХО, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа ажлаас 7,579,112.3 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 34 ажлын гэрээний хугацаа дууссан боловч гүйцэтгэл хангалтгүй байна.

“Барих шилжүүлэх” концессын төрлөөр хэрэгжүүлсэн ажлын талаар:

Төсвийн тухай хуульд 2018 онд Концессын төрлөөр хэрэгжүүлж байгаа Алтай-Дарви чиглэлийн 98 км хатуу хучилттай авто замын ажлыг 117,042.0 мянган төгрөгөөр, Алтай-Дарви чиглэлийн 165 км хатуу хучилттай авто замын ажлыг 176,405.4 мянган төгрөгөөр нийт 293,447.4 мянган төгрөгөөр хэрэгжүүлэхээр баталсан байна. Аудитаар ажлын явцтай танилцаж зурагжууллаа. Ажил гүйцэтгэх гэрээ, санхүүжилт, явцын хяналтын баримт материалыг барилга хөгжлийн яамнаас үзэх тул аудитад хамрагдсангүй.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын тухайд:

Тайлант онд Төсвийн тухай хуульд Говь-Алтай аймагт 34,607.7 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 25 төсөл арга хэмжээг баталжээ. Төсвийн тухай хуульд тусгагдан хэрэгжиж байгаа 25 төсөл, арга хэмжээний 13 ажил аймагт эрх шилжиж ирсэн, 12 ажлын эрх шилжиж ирээгүй байна.

Аудитаар төсөл арга хэмжээнүүдийг үндэслэлтэй төлөвлөсөн эсэхийг эрх шилжиж ирсэн 13 төсөл арга хэмжээний хүрээнд судалж үзэхэд аймгийн хөгжлийн цогц бодлого, үндсэн чиглэл, орон нутагт хэрэгжүүлэх тэргүүлэх ач холбогдол бүхий ажлын жагсаалтад орсон, газрын гэрчилгээ, техникийн нөхцөл байдлыг бүрэн тусгаж баримтжуулсан, Барилгын тухай хуульд заасны дагуу зураг төсөв боловсруулан Барилгын хөгжлийн төвөөс магадлал хийсэн байна. Үнэлгээний хороо байгуулан, нээлттэй тендер 8, харьцуулалтын аргаар 5 тендер шалгаруулан худалдан авах ажиллагааг зохион байгуулжээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд эрх шилжиж ирсэн 13 ажлыг 9,030,120.8 мянган төгрөгийн төсөвт өртгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулсан бөгөөд 8 ажлын хэрэгжилт хангалтгүй дуусаагүй байна. Үүнд: /УТХО-Хавсралт-1, 2/

- ✓ Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын ЗДТГ-ын газрын барилгын ажлыг 970,000.0 мянган төгрөгийн төсөвт өртгөөр 2018/07/01-2018/11/01-ний дотор хийж дуусгах гэрээ байгуулсан ба ажлын явц 30 хувьтай, 733,950.8 мянган төгрөгийн санхүүжилтийг олгоогүй байна.
- ✓ Чандмань, Эрдэнэ сумдад Ундны усны хангамжийг сайжруулах, ус цэвэршүүлэх тоног төхөөрөмж суулгах ажлыг 198,000.0 мянган төгрөгийн төсөвт өртгөөр 2018/09/26-2018/12/10-ний дотор хийж дуусгах гэрээ байгуулсан ба ажил явц хангалтгүй эхлэх шатандаа санхүүжилт олгогдоогүй байна.
- ✓ Тайшир сумын 75 ортой цэцэрлэгийн барилгын ажлыг 870,061.3 мянган төгрөгийн төсөвт өртгөөр 2015/06/20-2018/11/01-ний дотор хийж дуусгах гэрээ байгуулсан ба ажлын явц 91 хувьтай, 177,722.6 мянган төгрөгийн санхүүжилт олгоогүй байна.
- ✓ Дарив сумын 320 хүүхдийн суудалтай хичээлийн барилгын ажлыг 1,096,821.6 мянган төгрөгийн төсөвт өртгөөр 2018/07/20-2018/11/25-ний дотор хийж дуусгах гэрээ байгуулсан ба ажлын явц 33 хувьтай, 783,494.4 мянган төгрөгийн санхүүжилт олгогдоогүй байна.
- ✓ Чандмань сумын 320 хүүхдийн суудалтай хичээлийн барилгын ажлыг 1,988,500.0 мянган төгрөгийн төсөвт өртгөөр 2018/06/21-2018/11/01-ний дотор хийж дуусгах гэрээ байгуулсан ба ажлын явц 30 хувьтай, 1,988,500.0 мянган төгрөгийн санхүүжилт олгогдоогүй байна.
- ✓ Чандмань сумын 100 хүүхдийн дотуур байрны барилгыг ажлыг 850,000.0 мянган төгрөгийн төсөвт өртгөөр 2018/08/30-2018/11/30-ний дотор хийж дуусгах гэрээ байгуулсан ба ажлын явц 40 хувьтай, 599,096.5 мянган төгрөгийн санхүүжилтийг олгоогүй байна.

- ✓ Дарив сумын Эрүүл мэндийн төвийн барилгын ажлыг 1,289,030.0 мянган төгрөгийн төсөвт өртгөөр 2018/06/04-2019/09/25-ний дотор хийж дуусгах гэрээ байгуулсан ба ажлын явц 50 хувьтай, 1,289,030.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгоогүй байна.
- ✓ Цогт сумын Эрүүл мэндийн төвийн барилгын ажлыг 1,438,000.0 мянган төгрөгийн төсөвт өртгөөр 2018/08/27-2019/07/30-ний дотор хийж дуусгах гэрээ байгуулсан ба ажлын явц 30 хувьтай, 1,438,000.0 мянган төгрөгийн санхүүжилт олгогдоогүй байна.
- ✓ Төгрөг сумын Сургуулийн барилгын их засварын ажлыг 68,669.6 мянган төгрөгийн төсөвт өртгөөр 2018/08/16-2018/09/10-ний дотор хийж дуусгах гэрээ байгуулсан ба ажлын явц 100 хувь хэрэгжсэн, 15,262.9 мянган төгрөгийн санхүүжилт дутуу байна.
- ✓ Тайшир сумын Сургуулийн дотуур байрны засварын ажлыг 75,505.3 мянган төгрөгийн төсөвт өртгөөр 2018/10/24-2018/12/25-ний дотор хийж дуусгах гэрээ байгуулсан ба ажлын явц хангалтгүй эхлээгүй, 75,505.3 мянган төгрөгийн санхүүжилт олгогдоогүй байна.
- ✓ Дэлгэр сумын дотуур байрны их засварын ажлыг 59,855.7 мянган төгрөгийн төсөвт өртгөөр 2018/09/04-2018/10/19-ний дотор хийж дуусгах гэрээ байгуулсан ба ажлын явц 90 хувьтай ажлыг хүлээлгэн өгөх тоотыг захиалагчид хүргүүлсэн, 59,855.71 мянган төгрөгийн санхүүжилт олгогдоогүй байна.
- ✓ Есөнбулаг сумын 6-р цэцэрлэгийн ажлыг 56,977.3 мянган төгрөгийн төсөвт өртгөөр 2018/08/01-2018/08/21-ний дотор хийж дуусгах гэрээ байгуулсан ба ажлын явц 100 хувьтай 1,053.8 мянган төгрөгийн санхүүжилт олгоогүй байна.
- ✓ Баян-Уул, Дэлгэр сумын Гуулин тосгоны ЗДТГ-ын авто машины нийлүүлэх ажлыг 68,700.0 мянган төгрөгийн төсөвт өртгөөр 2018/06/15-2018/06/20-ний дотор хийж дуусгах гэрээ байгуулсан ба ажлын явц 100 хувьтай санхүүжилтээ бүрэн авсан байна.

Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, сунгалт хийсэн чанаргүй удаашралтай байгаа ажлуудын талаар захиалагч байгууллагуудад хяналт тавьж ажиллах шаардлагатай байна. Хэрэгжиж дууссан 3 ажлын хяналтын зардал 14,475.5 мянган төгрөгийг захиалагчийн зүгээс хяналтыг хэрэгжүүлсэн баримтыг үндэслэн ГХБХБГ-т шилжүүлэх нь зүйтэй байна.

/УТХО-Хавсралт-03/

Эрх шилжээгүй бусад ажлын талаар:

Төсвийн тухай хуулиар аймагт эрх шилжиж ирээгүй 25,181.8 мянган төгрөгийн өртөгтэй 12 ажил байна. Эрх шилжиж ирээгүй ажлын гүйцэтгэл 20-90 хувийн хэрэгжилттэй байна. Эрх шилжиж ирээгүй төсөл арга хэмжээний ажлын санхүүжилтийг тооцох боломжгүй байна. /УТХО-Хавсралт-04/

Орон нутгийн хөрөнгө оруулалтын тухайд:

ОНХО-аар хийгдэж байгаа ажлын худалдан авах ажиллагаа, гэрээ, үе шатны хяналт, санхүүжилт, хэрэгжилтийг үзэхэд дараах асуудал байна. Үүнд:

- ✓ ОНХО-аар 50,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий аймгийн ЗДТГ-ын автомашины засварын ажлын тухайд худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүйгээр шууд санхүүжүүлсэн.
- ✓ Орон нутгийн төсвөөс улсын төсвийн байгууллага болох Мэргэжлийн хяналтын газарт 25,000.0 мянган төгрөгийн автомашины хөрөнгө оруулалт хийсэн.
- ✓ ОНХО-аар хийгдсэн 1,022,768.4 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 14 төсөл арга хэмжээний гэрээний хугацаа дууссан байхад гэрээг дүгнэж хүлээж аваагүй байна.
- ✓ Дэлгэр сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд тоглоомын талбай байгуулах ажлын хүрээнд 9,000.0 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч хөрөнгө оруулалтын ажил огт хэрэгжээгүй байна. /ОНХО-Хавсралт-2/

ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтын талаар:

Орон нутгийн удирдлага улсын төсвөөс орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор хуваарилагдсан хөрөнгийг төлөвлөх, батлах, хуваарилах, нутгийн захиргаа, иргэд, олон нийтийн оролцоотой хамтын шийдвэрээр ил тод хариуцлагатай захиран зарцуулах, хяналт тавих, тайлагнах үйл ажиллагааг Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”, 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ыг баримтлан хэрэгжүүлж байна.

Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хуулийн 17 дугаар зүйлд ОНХНС болон улсын төсвөөс Говь-Алтай аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 3,399,300.0 мянган төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих урсгал зарлагын хэмжээг 488,200.0 мянган төгрөгөөр баталжээ.

Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Тогтвортой амьжиргаа-3” төслийн хүрээнд Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг орон нутагт дэмжих, орон нутгийн хөгжлийн сангийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, сайн гүйцэтгэлийг нэмэлт хөрөнгө хуваарилах замаар урамшуулах, төслийн удирдлага, хяналт-шинжилгээ үнэлгээ хийх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Сумдын ОНХС-ийн үйл ажиллагааг үнэлж, хуваарилсан хөрөнгийн тодорхой хувийг урамшуулах замаар олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрөөс 2018 онд сумдын ОНХС-д 32,021.1 мянган төгрөгийн урамшуулал, 726,762.8 мянган төгрөгийн дэмжлэг олгосон байна.

ОНХС-ийн хувьд шууд зардалд хуваарилсан төсвийг эс тооцвол аймгийн хэмжээнд 2018 онд ОНХС-аас хэрэгжүүлэхээр нийт 3,012,505.5 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 144 төсөл арга хэмжээг баталсан бөгөөд 116 төсөл арга хэмжээг 2,485,530.5 мянган төгрөгөөр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан 1,912,232.6 мянган төгрөгийг санхүүжүүлсэн байна.

ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтыг үзэхэд дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- ✓ Иргэдээс санал аваагүй эрэмбэлэгдээгүй 204,301.7 мянган төгрөгийн 16 төсөл арга хэмжээг ИТХ-аар шууд хэлэлцэн санхүүжүүлсэн.
- ✓ Аймгаас 8 сумд олгох шилжүүлгийг ИТХ-аар батлахдаа холбогдох хууль дүрэм зааврыг зөрчин сумдын хооронд үндэслэлгүйгээр 103,021.2 мянган төгрөгийг нэмж хасаж баталсан.
- ✓ ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлын зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл, төсвийн тооцоолол, төсөвт нөлөөлөх байдлын үнэлгээ хийж, хэрхэн шийдвэрлэх тухай санал тусгагдаагүй 2,924,517.9 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 109 ажлыг ИТХ-аар төсөв тавьж шууд баталсан.
- ✓ Цогт, Жаргалан сумд "Жишиг гудамж" төслийн ОНХС-аас хэрэгжих ажлын 60,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг төсөвт батлаагүй.
- ✓ Сумын ИТХ-аар төсөв батлаагүй байхад 3 ажлыг 21,836.9 мянган төгрөгөөр санхүүжүүлэн, зааварт нийцээгүй 492,795.2 мянган төгрөгийн 9 төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн.
- ✓ ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн 30,900.0 мянган төгрөгийн өртөг бүхий 2 төсөл арга хэмжээг худалдан авах ажиллагааг зохион байгуулалгүйгээр шууд гэрээ байгуулсан.
- ✓ Орон нутгийн төсвөөс улсын төсвийн байгууллага болох УЦУОШГ-т 13,000.0 мянган төгрөгийн харуулын барилга тоног төхөөрөмж, Татварын хэлтэст 40,000.0 мянган төгрөгийн автомашин, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт хийсэн.
- ✓ ОНХС-аар хийгдсэн 447,600.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 12 төсөл арга хэмжээний гэрээний хугацаа дууссан байхад гэрээг дүгнэж хүлээж аваагүй байна.
- ✓ ОНХС-аас хэрэгжүүлсэн 364,629.5 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 16 төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэлд захиалагчийн хяналт, 59,411.1 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 8 төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэлд ИТХ-ын дэргэдэх хяналтын хороо хяналт тавьж ажиллаагүй байна.

Дэд зорилт-4: ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүн зорилтот түвшинд нийцсэн эсэх

ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүн зорилтот түвшинд нийцсэн эсэхийг 2018 оны жилийн гүйцэтгэлээр дүгнэхээр байна.

4.1 ТЕЗ-ийн хэрэгжүүлж буй хөтөлбөр арга хэмжээний чанарын болон тоон үзүүлэлт зохистой байна уу?

Говь-Алтай аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн 2018 оны зорилтот түвшний биелэлтийг жилийн гүйцэтгэлээр гаргахаар хүлээгдэж байна.

ЗГ-ын хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 302 тоот тушаалын 1 дүгээр хавсралтаар “Аймаг, нийслэлийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийг 2016 - 2020 он хүртэл тодорхойлон баталж өгчээ.

Говь-Алтай аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт Хүснэгт №9

№	Шалгуур үзүүлэлт	2017 оны суурь үзүүлэлт	Хүрсэн үр дүн, гүйцэтгэл	2018	
				Зорилтот түвшин	Хүрсэн үр дүн, гүйцэтгэл
1	Дотоод нийт бүтээгдэхүүн /сая.төг/	238,387.2	257,827.9	277,328.6	
2	Төсөв				
	I төсвийн орлогын бүрдүүлэлт /сая/	5,877.9	7,242.2	5,936.7	
	II Төсвийн хэмнэлт/хувь/	0.1	2.5	0.1	
3	Сангийн эргэн төлөлт				
	I ЖДҮ-ийг хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн хувь	100.0	97.5	100.0	
	II ХЭДС-ийн эргэн төлөлтийн хувь	100.0	100.0	100.0	
4	Хөдөлмөр эрхлэлт				
	I ажилгүйдлийн түвшин	9.4	8.6	9.3	
	II Шинээр бий болгосон байнгын ажлын байрны тоо	410.0	1,275.0	430.0	
5	Хэрэглээний үнийн индекс	103.4		104.0	
6	Мал аж ахуй				
	I Малын тоо өсөлт/ мян толгой/	3,600.0	3,801.6	3,700.0	
	Мал аж ахуй	24.0	22.0	27.0	
	а. Аж ахуйн тоо	1,650.0	1,450.0	1,890.0	
	б. Малын тоо				
7	Газар тариалан				
	I хураан авсан үр тариа	0.6	0.3	0.7	
	II хураан авсан малын тэжээл бусад таримал/мян. тн/	1.5	1.7	1.6	
	III хураан авсан хүнсний ногоо	0.6	1.5	0.7	
8	Идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ын тоо	802.0	697.0	836.0	
9	Дэд бүтцэд холбогдсон орон сууцан амьдарч буй иргэдийн хувь	11.1	13.0	11.2	
10	Шинэ санал санаачлага, боловсруулан хэрэгжүүлэх, эдийн засаг				
	Нийгмийн хөгжлийн үзүүлэлт				
11	Iргэдийн шилжилт хөдөлгөөний цэвэр коэффициент /шилжин ирсэн хүн	(7.6)	(7.0)	24.4	
12	Хүний хөгжил				
	I хүний хөгжлийн индекс	0.7		0.7	
	II Ж өндөрийн тэгш бус байдлын индекс	0.8		0.8	
	Гэмт хэрэг				
	I бүргэгдсэн гэмт хэргийн бууралтын хувь	0.5	21.9	1.0	
	II иргэдэд учирсан хохиролын нөхөн төлөлтийн түвшин	66.0	36.4	66.2	
	III Гэмт хэргийн илэрүүлэлт бууралтын хувь	70.0	62.4	68.0	
14	агаар дахь бохирдуулагч бодисын жилийн дундаж агууламжийн түвшин				
	I Азотын давхар исэл	0.1	0.0	0.0	
	II хүхэрлэг хий	0.1	0.0	0.0	
15	Эрүүл мэнд				
	I эх нялхасын эндэгдлийн түвшин	16.2	16.4	16.0	
	II халдварт өвчнөөр өвчлөгсдийн түвшин	172.0	138.5	170.0	
16	Боловсрол				
	I Цэцэрлэг хамрадалтын хувь	90.0	90.1	90.2	
	II Сургууль хамрадалтын хувь	88.3	87.5	89.0	
	III Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн цэцэрлэг сургуульд хамрадалтын	91.7	95.0	92.3	
	IV Элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноо	468.0	506.3	469.0	
	VI шинээр ашиглалтанд орсон цэцэрлэг сургуулийн тоо	2.0	2.0	2.0	

Говь-Алтай аймгийн 2018 оны нийгэм эдийн засгийн үзүүлэлтийн зорилтот түвшний биелэлтийг ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс нь 2018 оны 09 сарын байдлаар гаргаагүй байгаа бөгөөд жилийн гүйцэтгэлээр гаргахаар хүлээгдэж байна.

Аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газарт бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 9 дугаар сарын байдлаар 874 байгаагийн 54.8 хувь нь буюу 479 нь эмэгтэйчүүд байна. Эдгээр ажилгүй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 159 хүнээр буюу 22.2 хувиар өсжээ.

Аймгийн хэмжээнд 2018 оны 09 сарын байдлаар 973 эх амаржиж 985 хүүхэд мэнд төрлөө. Нялхсын эндэгдлийн 16, 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 4 тохиолдол бүртгэгджээ.

Аймгийн дүнгээр төллөх насны хээлтэгчийн 56.9 хувь болох 862.3 мянган толгой хээлтэгч мал төллөж, 844.9 мянган төл 98.0 хувиар бойжиж байна. Төлийн хорогдол 17676 гарсан ба төрлөөр нь авч үзвэл 427 унага, 533 тугал, 150 ботго, 5272 хурга, 11294 ишиг тус тус хорогджээ. 9 сарын байдлаар аймгийн хэмжээнд 131.7 мянган толгой том мал зүй бусаар хорогдсон ба өмнөх оны мөн үетэй харьцуулахад 19 дахин их байна. Том малын зүй бусын хорогдлыг малын төрлөөр авч үзвэл адуу 1382, үхэр 2280, тэмээ 189, хонь 32389, ямаа 95485 байна. Нийт хорогдлын 24.6 хувийг хонь, 72.5 хувийг ямаа эзэлж байна.

4.2 ТЕЗ-д Төсвийн тухай хуулиар батлагдсан хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлж, төсвийг зориулалтын дагуу зарцуулж байна уу?

Төсвийг хуулийн хүрээнд зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах нь зүйтэй юм.

ТЕЗ-ийн 2018 оны 3 дугаар улирлын байдлаар төсвийн гүйцэтгэлийг хөтөлбөр, зориулалт, эдийн засгийн ангиллаар гаргаж дараах хүснэгтээр харуулж байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайлан хөтөлбөр, ангилалаар /2018.09.30/						мян.төгрөг
Хүснэгт №10						
Дугаар	Хөтөлбөр, ангилал	Жилийн төлөвлөгөө	Төлөвлөгөө /9.30/	Бодит гүйцэтгэл	Хэтрэлт хэмнэлт	Нийт зардлын эзлэх хувь
70105	ОН-ын өөрөө удирд ёсны байгууллага	1,303,748.0	1,000,385.0	940,843.3	59,541.7	92.3
70106	ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдах байгууллага	15,669,612.1	12,496,878.8	10,960,843.5	1,536,035.3	87.3
70417	Мэргэжлийн хяналт	87,714.1	66,795.9	60,633.0	6,162.9	90.8
70426	Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх	117,518.3	93,248.7	78,631.5	14,617.2	83.5
70503	Орон нутгийн зорилтот ХОруулалт	3,389,665.6	2,583,784.9	1,624,394.6	959,390.3	62.9
70709	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	293,435.2	226,289.9	200,117.6	26,172.3	88.4
71403	Ойжуулалт	64,506.7	49,901.6	46,771.4	3,130.2	93.7
71411	Хирээлэн буй орчны бодлого, удирдлага	412,034.6	317,545.7	312,966.8	4,578.9	98.4
71504	Газрын зураглал, кадастр	354,722.1	260,481.7	231,780.0	28,701.7	86.9
71601	Нийгмийн эрүүл мэнд	247,349.3	185,508.8	185,508.8	0.0	100.0
71602	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	4,169,955.4	3,100,640.3	2,883,382.9	217,257.4	91.1
71701	Биеийн тамир спорт	466,131.2	318,521.4	313,162.6	5,358.8	97.1
71702	Соёл урлаг	2,335,070.9	1,734,325.9	1,657,272.8	77,053.1	94.1
71801	Сургуулийн өмнөх боловсрол	6,490,663.0	4,818,738.7	4,499,488.8	319,249.9	92.2
71802	Ерөнхий боловсрол	19,704,165.8	13,927,780.2	12,821,544.0	1,106,236.2	90.9
71806	Насан туршын болон албан бус боловсрол	98,821.4	75,017.4	69,032.0	5,985.4	88.5
71902	Нийгмийн халамж	5,303,714.9	4,104,133.6	3,672,237.4	431,896.2	89.5
72101	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	1,420,731.1	1,622,249.1	550,180.0	1,072,069.1	33.9
72208	Ахмад настны хөгжил хамгаалал			0.0	0.0	
	Дүн	62,532,274.20	47,407,250.90	41,443,215.5	5,964,035.4	86.6

Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны төсвийг 20 хөтөлбөрөөр төлөвлөж, гүйцэтгэлийг харьцуулан үзэхэд хамгийн бага гүйцэтгэлтэй “Жижиг дунд

үйлдвэрлэлийг дэмжих” хөтөлбөр 39%-ийн гүйцэтгэлтэй байхад хамгийн их гүйцэтгэлтэй хөтөлбөр “Нийгэм эрүүл мэнд” хөтөлбөр 100%-ийн гүйцэтгэлтэй байна.

Төсвийн зарцуулалтын хувьд дараах эрсдэлтэй асуудлуудыг авч үзлээ.

УИХ-ын 67-р тогтоол:

УИХ-ын 67 дугаар тогтоолын дагуу сахилга хариуцлага, ажлын үр дүнгийн урамшуулалд ТЕЗ-ийн хүрээнд 914,876.4 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Төсөвт байгууллагууд 302 ажилтан албан хаагчдад ажлын үр дүнг дүгнээгүй байтал УИХ-ын 67 дугаар тогтоолоор 90,670.0 мянган төгрөгийн урамшууллыг олгосон байна. Үүнээс 3,972.9 мянган төгрөгийг буцаан төлүүлжээ. Мөн УИХ-ын 67 дугаар тогтоол нь хүчин төгөлдөр, сахилга хариуцлага, ажлын үр дүнгийн урамшуулалтай холбоотой хууль эрх зүйн шийдвэр гараагүй байхад батлагдсан төсөвт уг зардлыг цалингийн зардалд шилжүүлэн төсвийн зохицуулалт хийсэн нь үндэслэлгүй байна. /Зарцуулалт-хавсралт-1/

Түлш халаалтын зардлын талаар:

2017 оны 11-12 дугаар сард “Мандал Голомт” ХХК-ийн халаалтын хоёрдугаар зууханд удаа дараа аваар саатал гарч Эрчим хүчний тухай хуулийн 291.1¹³, 30.1.1¹⁴, мөн “Дулаан эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн 10 дугаар бүлгийн 60¹⁵ дахь заалт, дулаан эрчим хүчээр хангах хэрэглэх тухай гэрээнд заасан 95/70-ийн градустай температурын графикаас доогуур градустай дулаан нийлүүлсэн бөгөөд Эрчим хүчний зохицуулах хорооноос халаалт доголдож байх үеийн температурт харьцуулсан бууралтын хувь хэмжээ, бусад хүчин зүйл нөлөөлөл зэргийг тооцон дулааны төлбөрийг хөнгөлөх шийдвэр гаргасан байна. Тус компани нь хоёрдугаар зуухнаас дулаан авдаг айл өрхийн төлбөрөөс 28 хоногийн төлбөрийг хасч тооцсон хэдий ч 11 албан байгууллагын халаалтын төлбөрөөс хасалт хийгээгүй байна. Уг 11 байгууллагын халаалтын төлбөрийг 28 хоногоор тооцвол нийт 121.600,3 мянган төгрөгийг “Мандал Голомт” ХХК-д дутуу төлөхөөр тооцоо гарч байна. Иймд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1¹⁶ дэх заалтын дагуу үр ашиггүй зардлыг бууруулж төсвийг хэмнэлттэй зарцуулах нь зүйтэй юм. /Зарцуулалт-хавсралт-2/

Гамшгаас хамгаалах сангийн хөрөнгөөр бэлтгэсэн өвс тэжээлд хийсэн хөрөнгийн тооллого, тооцооны талаар:

Гамшгийн сангийн эрсдэлийг бууруулах зорилгоор 17 сумдад 170.0 сая төгрөгийн өвс, тэжээлийн нөөц нийлүүлэхээр “Хишигт Халиун” ХХК-тай гэрээ байгуулжээ. Сумдын ЗДТГ-т нийлүүлсэн өвс тэжээлд биет тооллого хийхэд:

- ✓ Борлуулсан өвс тэжээлийн үнэ болох 32,393.1 мянган төгрөгийг төвлөрүүлээгүй байна.
- ✓ Тооллогоор “Хишигт Халиун” ХХК нь 20,220.0 мянган төгрөгийн өвс тэжээлийг 5 сумдад дутуу нийлүүлэн гэрээний үүргээ хэрэгжүүлээгүй байсан бөгөөд аудитын явцад 9,816.0 мянган төгрөгийн өвс тэжээлийг 2 сумд нийлүүлж үлдсэн 10,404.0 мянган төгрөгийн өвс тэжээлийг огт нийлүүлээгүй байна.

“Хишигт Халиун” ХХК нь гэрээнд заасан хугацаанд үүргээ хэрэгжүүлээгүй, зарим сумдад өвс тэжээлийг хүргэж өгөөгүйгээс төсөвт байгууллагаас тээврийн болон шатахууны зардал гарсан байгааг дахин нягталж дутуу өвс тэжээлийг нийлүүлэх, гэрээнд заасны дагуу алданги тооцох шаардлагатай байна. /Гамшиг өвс-хавсралт-1/

Мөн төсөвт байгууллагууд борлуулсан 26,825.5 мянган төгрөгийн өвс тэжээлийн үнийг сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн байна. Аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсээс “ОНХС-д өвс тэжээлийн орлого орж байгаа тул зарцуулахдаа хаасан орлогоос, орсон орлогын хэмжээгээр зарцуулж, сумын төсвийн тодотголоор ОНХС-г (70503 хөтөлбөрийн 82705 арга хэмжээ) нэмэгдүүлэн баталж, холбогдох залруулгын бичилт хийнэ үү.” гэсэн албан бичгийг сумдад хүргүүлсэн байна. Гэвч сумдад Гамшгаас хамгаалах

¹³ Стандартын шаардлагад нийцсэн эрчим хүчээр хэрэглэгчийг хангах

¹⁴ Стандартын шаардлагад нийцсэн эрчим хүчээр хангагдах

¹⁵ Чанарыг бууруулан түгээсэн дулаан эрчим хүчний төлбөр тооцоог тухайн хэрэглэгчийн хянах, хэмжих хэрэгсэлийн заалтаар тогтоож хийнэ.

¹⁶ Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

сангийн тусгай данс байхгүй, ОНХС-ийн дансаар дээрх хөтөлбөр арга хэмжээг Сангийн яамнаас бий болгоогүй байна. Зарим сум ОНХС-д төвлөрүүлсэн өвс тэжээлийн мөнгөнөөс буцаан өвс тэжээл бэлтгэн зарцуулалт хийж байгаа нь ОНХС-ийн журмыг зөрчсөн үйл ажиллагаа болж байна. Иймд энэ зөрчигдөж байгаа асуудлыг нэн даруй шийдвэрлэх нь зүйтэй байна.

4.3 Хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтэд тавих дотоод хяналт хангалттай байна уу?

ТЕЗ-ийн дотоод хяналтыг чанартай зохион байгуулж, үр дүнг тайлагнаж байх шаардлагатай байна.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 01 дүгээр албан даалгавар, 2018 оны 258 дугаар тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2018 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 255 дугаар тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2018 оны А/371 дүгээр захирамжаар аймгийн Засаг даргын Тамгын газрын даргаар ахлуулсан 29 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулан 09 дүгээр сарын 10-13-ны өдрүүдэд Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 21 хэрэгжүүлэгч агентлаг, хөдөөгийн 17 сум, 2 тосгоны 107 байгууллага, аймгийн төв Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газар болон тус сумд үйл ажиллагаа явуулж буй боловсрол, соёл, эрүүл мэндийн 25 байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит байгууллагууд болох “Гэгээн нуур цэвэр ус”, “Ундарга-Алтай” ОНӨААТҮГ-ууд, Алтай хотын тохижилт үйлчилгээний газар нийт 160 байгууллагын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч ажиллалаа.

Хяналт, шалгалтын дүнг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн бөгөөд шалгалтад хамрагдсан байгууллагуудын үйл ажиллагаатай холбогдуулан цаашид авах арга хэмжээний талаарх зөвлөмжийг өгч хэрэгжилтэд хяналт тавин ажиллахаар болсон байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс нь ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний энэ оны эхний хагас жилийн хэрэгжилтийн тайланг гаргахдаа 91 арга хэмжээний хэрэгжилтийг холбогдох хэлтэс, агентлаг, сумдаас авч нэгтгэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байна. Хяналт хийснээр тухайн арга хэмжээний хэрэгжилтийг бичиж тайлагнахдаа зарцуулсан хөрөнгийг эх үүсвэр тус бүрээр тооцож гаргах, аймагт хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын мэдээ, тайланг сумдын Засаг даргын болон байгууллагын даргын зөвлөлийн хурлаар авч хэлэлцэн ажлыг эрчимжүүлэх, аймгийн төв Есөнбулаг сумын хэмжээнд түрээсэлж буй орон сууц болон орон сууц түрээслэн амьдардаг өрхийн тоог гаргах, сумдад хэрэгжүүлсэн арга хэмжээг нэгтгэх, хэрэгжилт хангалтгүй, удаашралтай байгаа арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх талаар санаачилгатай ажиллахыг зөвлөсөн байна.

Санхүү төрийн сангийн хэлтсээс 2018 онд Дэлгэр, Тонхил, Хөхморьт, Шарга, Тайшир сумдын Санхүүгийн албаны үйл ажиллагаа, төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт, төсөвт байгууллагуудын төсвийн гүйцэтгэл, жилийн хүлээгдэж буй гүйцэтгэл, өр авлага барагдуулалт, төрийн сангийн үйл ажиллагааны журмын хэрэгжилт, аймгийн Засаг даргын 2017 оны 01 дүгээр албан даалгаврын биелэлт, төрийн аудитын байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх талаар зохион байгуулсан арга хэмжээтэй танилцаж, шалган туслах үйлчилгээ үзүүлсэн байна. Уг ажлын үр дүнд дээрх сумдад амлалтын бүртгэл хөтлөх, зарлагын дансанд гарын үсгийн баталгаа гаргах, төрийн сангийн журмыг мөрдөж ажиллах, төрийн сангийн нэгжийн мемориалын баримтыг бүрдүүлэх, материалыг бүрэн оруулж, өр авлага үүсгэлгүй ажиллах, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, өр авлагыг мэдээг төсвийн байгууллагын дарга, нягтлан бодогч нараар гарын үсэг зуруулан баталгаажуулж авах, оны эхний өр, авлагын үлдэгдлийг фрийбаланс программд оруулж өгөх гэх мэт давхардсан тоогоор 73 зөвлөмж өгч ажилласан байна. Гэвч аудитаар илэрч байгаа зөрчлийг харахад дотоод хяналтыг чанартай зохион байгуулж, өгсөн зөвлөмжийн үр дүнг тайлагнаж байх шаардлагатай байна.

ИЛРҮҮЛЭЛТ:**Орон нутгийн орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт, гүйцэтгэлийн талаар:**

1. Аймаг сумдын батлагдсан төсвийн орлогыг нэр төрөл, бааз сууриар бодит гүйцэтгэлтэй тулган баталгаажуулахад аймагт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг 360,041.3 мянган төгрөгөөр, сумд төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг 331,132.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.
2. Сумдын батлагдсан төсвийн орлогыг нэр төрлөөр, бодит гүйцэтгэлтэй тулган баталгаажуулахад 4 төрлийн 1,933.8 мянган төгрөгийн орлогыг хий төлөвлөсөн тул орлого бүрдүүлэх боломжгүй байна.
3. Төрийн сангийн орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлийг тулган баталгаажуулахад нийт дүнгээрээ татварын орлогын мэдээнээс 424,914.3 мянган төгрөгөөр, аудитаар тооцсон орлогын гүйцэтгэлээс 458,073.7 мянган төгрөгөөр тус тус дутуу буюу зөрүүтэй тайлагнагдсан.
4. УТХО-аар жижиг дунд үйлдвэрлэл, эрчимжсэн газар тариалан, жимс жимсгэнэ, хүлэмжийн аж ахуйг дэмжих зорилгоор хоршоо, иргэдэд олгосон зээлээс эргэн төлөгдөх хугацаа дууссан боловч одоогийн байдлаар 55 иргэн, ААНБ, хоршоотой холбоотой 783,203.6 мянган төгрөгийн зээлийг төлүүлээгүй.
5. Жижиг дунд үйлдвэрлэл, эрчимжсэн газар тариалан, жимс жимсгэнэ, хүлэмжийн аж ахуйг дэмжих зорилгоор хоршоо, иргэдэд олгосон зээлийн үлдэгдлээс 11 зээлдэгчийн 147,100.0 мянган төгрөгийн зээлийг Шүүхэд хандаж төлүүлэх хэмжээ аваагүй байна.

Сургууль цэцэрлэгийн хувьсах болон нормативт зардлын төлөвлөлтийн талаар

6. Сургууль, цэцэрлэгийн хувьсах зардлын нормативаар тооцсон цалин хөлс болон ажил олгогчоос төлөх НДШ-ийг төлөвлөсөн дүнтэй харьцуулахад 6,368,433.6 мянган төгрөгөөр илүү төлөвлөгдсөн.
7. Бараа үйлчилгээний бусад хувьсах зардлыг нормативаар тооцож үзэхэд 11 сургуульд 8,499.8 мянган төгрөгөөр илүү, 5 сургуульд 3,410.3 мянган төгрөгөөр дутуу, 12 цэцэрлэгт 3,607.9 мянган төгрөгөөр илүү төлөвлөсөн.
8. Сургуулийн хоолны зардлыг 2018 онд 17 сургуульд 570,767.5 мянган төгрөгөөр илүү, 4 сургуульд 34,271.5 мянган төгрөгөөр дутуу, үдийн цайны зардлыг 19 сургуульд 384,084.0 мянган төгрөгөөр илүү, 7 сургуульд 5,152.4 мянган төгрөгөөр дутуу төлөвлөсөн.
9. Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг 2018 онд бодит гүйцэтгэлд тулгуурлан 320,572.6 мянган төгрөгөөр дутуу төлөвлөсөн.

Төсөвт болон ОНӨААТҮГ-ын төсвийн орлого нэмэгдүүлэх боломж, үйл ажиллагааны үр дүнгийн талаар

10. "Ундарга-Алтай" ОНӨААТҮГ газар нь автомашин, механизмаа түрээслэн олсон орлогын 60 хувь болох 3,774.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй.
11. "Гэгээн нуур цэвэр ус" ОНӨААТҮГ газар нь нь 0.5 литрийн уснаас 0.16 мянган төгрөгийн ашиг олж 19.8 литрийн уснаас 0.74 мянган төгрөгийн алдагдал хүлээж байгаа борлуулалтын тооцоо ирүүлсэн.
12. "Барилгын зураг төсвийн товчоо" ОНӨААТҮГ, "Орон сууцны алба" ОНӨААТҮГ-ыг татан буулгах шийдвэр гарсан боловч дуусгалтын тооцоо хийгдээгүй байна.

УТХО-ын төлөвлөлт, зарцуулалтын талаар

13. УТХО-аар бүрэн хийгдсэн 3 ажлын захиалагчийн хяналтын зардал 14,475.5 мянган төгрөгийг хяналт тавьсан байгууллагад шилжүүлээгүй.
14. 2018 онд эрх шилжиж ирсэн 8 төсөл арга хэмжээний 6,108,743.9 мянган төгрөгийн гэрээт ажлын явц хангалтгүй байна.
15. 2018 онд хийгдэж дуусах барилга байгууламж, төсөл арга хэмжээнд олгох 4,632,442.2 мянган төгрөгийн санхүүжилт дутуу байна.

ОНХО-ын хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтын талаар

16. ОНХО-аар хийгдэх ажлын техник эдийн засгийн үндэслэл, төсвийн тооцоолол, төсөвт нөлөөлөх байдлын үнэлгээ хийж, хэрхэн шийдвэрлэх тухай санал тусгагдаагүй 1,420,098.0 мянган төгрөгийн өртөг бүхий 14 ажлыг ИТХ-аар төсөв тавьж шууд баталсан.
17. ОНХО-аар 50,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий аймгийн ЗДТГ-ын автомашины засварын ажлын тухайд худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүйгээр шууд санхүүжүүлсэн.
18. Орон нутгийн төсвөөс улсын төсөвт байгууллага болох Мэргэжлийн хяналтын газарт 25,000.0 мянган төгрөгийн автомашины хөрөнгө оруулалт хийсэн.
19. ОНХО-аар хийгдсэн 1,022,768.4 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 14 төсөл арга хэмжээний гэрээний хугацаа дууссан байхад гэрээг дүгнэж хүлээж аваагүй.
20. Дэлгэр сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд тоглоомын талбай байгуулах ажлын хүрээнд 9,000.0 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч хөрөнгө оруулалтын ажил огт хэрэгжээгүй.

ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтын талаар

21. Иргэдээс санал аваагүй эрэмбэлэгдээгүй 204,301.7 мянган төгрөгийн 16 төсөл арга хэмжээг ИТХ-аар шууд хэлэлцэн санхүүжүүлсэн.
22. Аймгаас 8 сумд олгох шилжүүлгийг ИТХ-аар батлахдаа холбогдох хууль дүрэм зааврыг зөрчин сумдын хооронд үндэслэлгүйгээр 103,021.2 мянган төгрөгийг нэмж хасаж баталсан.
23. ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлын зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл, төсвийн тооцоолол, төсөвт нөлөөлөх байдлын үнэлгээ хийж, хэрхэн шийдвэрлэх тухай санал тусгагдаагүй 2,924,517.9 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 109 ажлыг ИТХ-аар төсөв тавьж шууд баталсан.
24. Цогт, Жаргалан сумд "Жишиг гудамж" төслийн ОНХС-аас хэрэгжих ажлын 60,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг төсөвт батлаагүй.
25. Сумын ИТХ-аар төсөв батлаагүй байхад 3 ажлыг 21,836.9 мянган төгрөгөөр санхүүжүүлэн, зааварт нийцээгүй 492,795.2 мянган төгрөгийн 9 төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн.
26. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн 30,900.0 мянган төгрөгийн өртөг бүхий 2 төсөл арга хэмжээг худалдан авах ажиллагааг зохион байгуулалгүйгээр шууд гэрээ байгуулсан.
27. Орон нутгийн төсвөөс улсын төсвийн байгууллага болох УЦУОШГ-т 13,000.0 мянган төгрөгийн харуулын барилга тоног төхөөрөмж, Татварын хэлтэст 40,000.0 мянган төгрөгийн автомашин, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт хийсэн.
28. ОНХС-аар хийгдсэн 447,600.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 12 төсөл арга хэмжээний гэрээний хугацаа дууссан байхад гэрээг дүгнэж хүлээж аваагүй байна.
29. ОНХС-аас хэрэгжүүлсэн 364,629.5 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 16 төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэлд захиалагчийн хяналт, 59,411.1 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 8 төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэлд ИТХ-ын хяналтын хороо хяналт тавьж ажиллаагүй.

ТБОНӨХБАҮХА тухай хуулийн хэрэгжилтийн талаар

30. Бугат, Төгрөг сумдын сургууль, цэцэрлэг, Тахийн тал, Алтансоёмбо, Олонбулагын бага сургууль нь худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүйгээр 103,188.7 мянган төгрөгийн хүнсний материалыг шууд худалдан авалт хийсэн.
31. Сумдын нам даралтын зуухтай төсөвт байгууллагуудын хувьд 627,132.0 мянган төгрөгийн түлшийг худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүйгээр шууд худалдан авалт хийсэн.
32. Төсөвт байгууллагууд 397,805.0 мянган төгрөгийн шатахууныг худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүйгээр шууд худалдан авалт хийсэн байна.

33. Аймгийн төвийн сургууль, цэцэрлэгүүд нь худалдан авах бараа үйлчилгээний тендер шалгаруулалтын тендерийн баримт бичгийн үнэ 2,250.0 мянган төгрөгийг бэлнээр авч зарцуулсан.
34. Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан баримт бичгийг харахад ажлын хэсэг байгуулахдаа гишүүдийн тоог тэгш тоотойгоор байгуулсан, АЗ сертификаттай гишүүн байхгүй байх, тендер шалгаруулалтын аргыг буруу сонгох, хуульд заасан хугацааг баримтлаагүй байх зэрэг зөрчилтэй асуудлууд байна.

Төсвийн зарцуулалтын талаар

35. Сумдын ЗДТГ-т гамшгийн сангийн эрсдэлийг бууруулах зорилгоор олгосон өвс тэжээлд биет тооллого хийхэд борлуулсан өвс тэжээлийн үнэ болох 32,393.1 мянган төгрөгийг төвлөрүүлээгүй.
36. Тооллогоор “Хишигт Халиун” ХХК нь 20,220.0 мянган төгрөгийн өвс тэжээлийг 5 сумдад дутуу нийлүүлэн гэрээний үүргээ хэрэгжүүлээгүй байсан бөгөөд аудитын явцад 9,816.0 мянган төгрөгийн өвс тэжээлийг 2 сумд нийлүүлж үлдсэн 10,404.0 мянган төгрөгийн өвс тэжээлийг огт нийлүүлээгүй байна.
37. ТЕЗ-ийн хүрээнд 302 ажилтан албан хаагчдад ажлын үр дүнг тооцоогүй байтал УИХ-ын 67 дугаар тогтоолоор 86,697.1 мянган төгрөгийн урамшууллыг олгосон.
38. “Мандал Голомт” ХХК-ийн техникийн доголдлоос шалтгаалан халаалт бүрэн өгөгдөөгүй байхад 11 төсөв байгууллагын халаагүй сарын төлбөр болох 121,600.3 мянган төгрөгийг суутган тооцоогүй.
39. УИХ-ын 67 дугаар тогтоол нь хүчин төгөлдөр, сахилга хариуцлага, ажлын үр дүнгийн урамшуулалтай холбоотой хууль эрх зүйн шийдвэр гараагүй байхад батлагдсан төсөвт уг зардлыг цалингийн зардалд шилжүүлэн төсвийн зохицуулалт хийсэн нь үндэслэлгүй байна.

Илрүүлэлтэд үндэслээд дараах дүгнэлтүүдийг гаргаж байна.

- Аймгийн 2018 оны төсөвт төвлөрүүлэх орлогыг 691,173.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөх боломжтой байна.
- Төсвийн зарлагыг журам заавар, норм нормативт үндэслэн бодитой төлөвлөөгүйгээс хууль эрх зүй зөрчигдөж зарцуулах эрсдэлийг бий болгож байна.
- Орон нутгийн орлогын төлөвлөгөөг нийт дүнгээр нь тооцвол аймагт 99 хувиар, сумд 145 хувиар биелүүлсэн байгаа хэдий ч 8 нэр төрлийн орлогын төлөвлөгөө 177,541.5 мянган төгрөгөөр тасарчээ.
- ОНТҮГ, ОНӨААТҮГ-уудын ашигт ажиллагааны түвшнийг тодорхойлж, төсвөөс дэмжлэг авалгүй өөрийн эх үүсвэрээр үйл ажиллагаагаа бүрэн явуулах боломжийг судлан хэрэгжүүлэх шаардлага тулгарсан байна.
- Төсвийн хэмнэлтийн 50 хувь нь ОНХО, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж байгаа ажлын санхүүжилтээс шалтгаалсан, 15 хувь нь сум хөгжүүлэх сангийн зээл олголттой холбоотой бодит бус хэмнэлт байна.
- Төсөвт байгууллагууд ТБОНӨХБАҮХА тухай хуулийг хангалтгүй хэрэгжүүлж байна.
- УТХО, ОНХО, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа ажлаас 7,579,112.3 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 34 ажлын гэрээний хугацаа дууссан боловч гүйцэтгэл хангалтгүй байна.
- ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүн зорилтот түвшинд нийцсэн эсэхийг 2018 оны жилийн гүйцэтгэлээр дүгнэхээр байна.

Ерөнхий Дүгнэлт

Хууль эрх зүйг чандлан мөрдсөнөөр төсвийг үр дүнтэй төлөвлөж зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах үндэслэл болохоор байна.

Дээрх дүгнэлтэд үндэслээд дараах шийдвэрийг гаргаж байна.

Зөвлөмж**Аймгийн ИТХ-ын дарга Т.Ганзоригт:**

1. Иргэдээс санал аваагүй, эрэмбэлээгүй, ТЭЗҮ, зураг төсөвгүй, ажлын даалгаваргүй, төсөвт нөлөөлөх ачааллыг тооцоогүй төсөл арга хэмжээг ИТХ-аар батлахгүй байх
2. ИТХ-ын дэргэдэх хяналтын хорооны хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлж, үр дүнг хэлэлцэн, зөрчлийг тухай бүр арилгуулж ажиллах

Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Ч.Жаргалсайханд:

1. Орон нутгийн орлогын гүйцэтгэлийн мэдээг бодитоор, үнэн зөв гаргаж байх
2. "Гэгээн нуур цэвэр ус" ОНӨААТҮГ-аар нэгж бэлэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд гарч буй зардал өртгийн тооцооллыг зах зээлийн ханшийн нэмэгдлийг оруулан тооцож төсвөөс авах дэмжлэгийн хэмжээг бууруулах арга замыг тодорхойлох

Албан шаардлага**ТЕЗ, аймгийн Засаг дарга С.Гансэлэмд:**

1. Худалдан авах ажиллагааг журмын дагуу зохион байгуулаагүй, шууд худалдан авалт хийсэн сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарт хуулийн дагуу хариуцлага тооцох
2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулах

Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Ч.Жаргалсайхан, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга С.Байгальмаа нарт:

1. Аудитаар тооцсон орлого нэмэгдүүлэх болон үндэслэлгүй төлөвлөсөн орлогыг төсөвт тодотгож гүйцэтгэлийг хангаж ажиллах
2. Жижиг дунд үйлдвэрлэл, эрчимжсэн газар тариалан, жимс жимсгэнэ, хүлэмжийн аж ахуйг дэмжих зорилгоор хоршоо, иргэдэд олгосон хугацаа хэтэрсэн зээлийг хуулийн байгууллагад хандаж шийдвэрлүүлэх
3. УТХО, ОНХО, ОНХС-ийн хөрөнгийг Төсвийн тухай хууль болон бусад холбогдох хууль эрх зүйг баримтлан хяналтыг сайжруулан, үр дүнтэй, үр ашигтай зарцуулах
4. Дутуу нийлүүлсэн өвс тэжээлийг “Хишигт Халиун” ХХК-аар төлүүлж төсвийг хохиролгүй болгож, гэрээнд заасны дагуу алданги тооцон төлүүлэх
5. Хууль тогтоомжийг мөрдөж ажиллаж, төсвийг хэмнэлттэй зарцуулах

БСУГ-ын дарга Р.Батмөнх, төсвийн мэргэжилтэн Д.Анхбаатарт:

1. Хувьсах зардлын нормативыг баримтлан төсвийг үндэслэлтэй төлөвлөх

Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Ойнбилэгт:

1. Татан буугдах шийдвэр гарсан “Орон сууцны алба”, “Барилгын зураг зүйн товчоо” ОНӨААТҮГ-ын хөрөнгийг хуулийн хүрээнд шийдвэрлэх

Төлбөрийн акт

Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Ч.Жаргалсайханд:

1. Жижиг дунд үйлдвэрлэл, эрчимжсэн газар тариалан, жимс жимсгэнэ, хүлэмжийн аж ахуйг дэмжих зорилгоор хоршоо, иргэдэд олгосон 783,203.6 мянган төгрөгийн зээлийг төлүүлж НББ-д авлагаар бүртгэж төлүүлэх
2. Төсөвт байгууллагын ажилтан албан хаагчдад ажлын үр дүнг тооцоогүй байхад УИХ-ын 67 дугаар тогтоолоор олгосон 86,697.1 мянган төгрөгийн урамшууллыг төлүүлэх.
3. Төсөвт байгууллагуудын Мандал Голомт ХХК-д төлөх халаалтын 121,600.3 мянган төгрөгийг суутган тооцож орон нутгийн орлогод төвлөрүүлэх.

"Ундрага-Алтай" ОНӨААТҮГ-ын захирал С.Булгантамир, нягтлан бодогч Г.Должинжав

1. Автомашин, механизмаа түрээслэн олсон орлогын 60 хувь болох 3,774.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх

Сумын ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч, няравт

1. Борлуулсан өвс тэжээлийн үнэ болох 32,393.1 мянган төгрөгийг ОНХС-ийн дансанд төвлөрүүлэх.

Уламжлах нь

ҮАГ-ын газарт:

1. Боловсролын салбарын хувьд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг баримтлан багшийн цалингийн зардлыг төлөвлөх нь ЗГ-ын 2018 оны “Төрийн зарим албан тушаалын цалингийн сүлжээ, дотоод жишгийг шинэчлэн тогтоох тухай” 264 дүгээр тогтоолоор олгох цалинтай уялдахгүй байгаа асуудлыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамд уламжлан шийдвэрлүүлэх

ДАРГА , ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР

Холбогдох байгууллагын санал

АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАРТ

2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явцад хийсэн аудитын тайлангийн шийдвэртэй танилцаж, өгсөн санал дүгнэлтийг зөвшөөрч байна.

Цаашид шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллах болно.

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Ч.ЖАРГАЛСАЙХАН



Ч.Жаргалсайхан
Аудитын тайлан

Ч.Ж. 2018.11.05

021549